



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-53
1.Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	15-16
2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	16-17
3.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэл/	17-18
4.Монгол Улын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	18-38
5.Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	38-43
6.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний чөлөөлөх тухай асуудал	43-44
7.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	44-54

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 23-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 73 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, П.Ганзориг, С.Лүндэг, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, О.Номинчимэг, А.Ундраа, Б.Уянга, Д.Цогтбаатар, С.Цэнгүүн, Ө.Шижир, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Э.Батшугар, Б.Дэлгэрсайхан, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Р.Батболд, Х.Баттулга, Х.Болормаа, Т.Доржханд, Н.Номтойбаяр;

Тасалсан: Н.Алтанхуяг, Н.Алтаншагай, Б.Батбаатар, Л.Гантөмөр, С.Одонтуяа, Ц.Туваан, Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр;

Хоцорсон: О.Амгаланбаатар-16 минут, Ц.Баатархүү-01 минут, Д.Батбаяр-01 минут, Б.Бат-Эрдэнэ-13 минут, Ж.Баярмаа-09 минут, Б.Бейсен-41 минут, Ж.Галбадрах-14 минут, А.Ганбаатар-41 минут, С.Ганбаатар-22 минут, Х.Ганхуяг-21 минут, М.Ганхүлэг-10 минут, Ц.Даваасүрэн-15 минут, Г.Дамдинням-21 минут, Б.Жаргалан-04 минут, Д.Жаргалсайхан-1 цаг 58 минут, Ч.Лодойсамбуу-13 минут, Л.Мөнхбаатар-06 минут, З.Мэндсайхан-02 минут, П.Наранбаяр-05 минут, Э.Одбаяр-1 цаг 21 минут, Б.Пунсалмаа-53 минут, Ц.Сандаг-Очир-16 минут, Б.Тулга-1 цаг 07 минут, Б.Түвшин-21 минут, Х.Тэмүүжин-01 минут, Г.Уянгахишиг-12 минут, Б.Хэрлэн-02 минут, Б.Чойжилсүрэн-04 минут, Ж.Энхбаяр-03 минут, Р.Эрдэнэбүрэн-13 минут.

Нэг.Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бад.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш нар байлцав.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Цусны донорын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 23

Бүгд: 78

64.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Д.Амарбаясгалан: 2.Байнгын хорооны саналаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 42

Бүгд: 78

46.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 36

Бүгд: 78

53.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Санал хураалтад оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцов./14:12/

4.Байнгын хорооны саналаар Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 36

Бүгд: 80

55.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Санал хураалтад оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцов./14:13/

5.Байнгын хорооны саналаар Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 26

Бүгд: 80

67.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, **хэлэлцэх эсэх**, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш нар байлцав.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	27
Бүгд:	84

67.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Д.Амарбаясгалан: 2.Байнгын хорооны саналаар Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	27
Бүгд:	84

67.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	26
Бүгд:	84

69.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Санал хураалтад оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцов./14:16/

4.Байнгын хорооны саналаар Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 21

Бүгд: 85

75.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 27

Бүгд: 86

68.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Санал хураалтад оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцов./14:18/

6.Байнгын хорооны саналаар Донорын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 26

Бүгд: 86

69.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 39
Бүгд: 86
54.7 хувийн саналаар буюу нийт гишүүдийн олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Санал хураалтад оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх хуулийн төслийг соёрхон батлахыг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцов./14:19/

Уг асуудлыг 14 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын дарга Л.Балчинлуvsан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж сайд нарын олонх байхгүй байгаа тул хэлэлцэх асуудлыг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 75

Бүгд: 90

16.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Б.Жавхлан, О.Цогтгэрэл, Ц.Мөнхтуяа, Д.Энхтуяа, Э.Болормаа, Г.Уянгахишиг, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсгийн “буюу АНУ-ын тарифын бодлогоос шалтгаалж санхүүгийн зах зээлд тогтворгүй нөхцөл байдал үүсэхээс өмнө” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 49

Бүгд: 96

49.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 2.7 дахь хэсгийн “2021 онд” гэснийг “2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр” гэж, “2024 онд” гэснийг “2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр” гэж, 3.1 дэх хэсгийн “02 дугаар сард” гэснийг “02 дугаар сарын 18-ны өдөр” гэж, 3.3 дахь хэсгийн “06 дугаар сард” гэснийг “06 дугаар сарын 16-ны өдөр” гэж, 3.5 дахь хэсгийн “09 дүгээр сард” гэснийг “09 дүгээр сарын 02-ны өдөр” гэж, 3.6 дахь хэсгийн “2021 онд” гэснийг “2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр” гэж, 3.7 дахь хэсгийн “05 дугаар сард” гэснийг “05 дугаар сарын 15-ны өдөр” гэж, 3.9 дэх хэсгийн “10 дугаар сард” гэснийг “10 дугаар сарын 04-ний өдөр” гэж, 3.11 дэх хэсгийн “2031 онд” гэснийг “2031 оны 10 дугаар сарын 28-нд” гэж, 3.12 дахь хэсгийн “08 дугаар сард” гэснийг “08 дугаар сарын 29-ний өдөр” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 41

Бүгд: 96
57.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн саналаа тайлбарлаж үг хэлэв.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 4.8 дахь хэсгийн “эхлүүлэх” гэснийг “тогтмол явуулах” гэж, “тогтмол арилжаалах төлөвлөгөөтэй байна.” гэснийг “Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг эхлүүлээд байна.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 38
Бүгд: 96
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын Стратеги 4-ийн “Улсын төсөв ДНБ-ний 2 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай үед” гэснийг “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй үед” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 39
Бүгд: 96
59.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийг дэмжсэнээр тооцож, 60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Д.Амарбаясгалан: 1. Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсгийн “түүхэн” гэсний өмнө “Засгийн газраас өмнө гаргаж байсан бондуудаас” гэж, 3.3 дахь хэсгийн “гаргасан” гэсний өмнө “баталгаа” гэж, 6.1 дэх хэсгийн “харьцааны төсөөллийг” гэсний өмнө “ДНБ-нд харьцуулсан” гэж, 6.2 дахь хэсгийн “хэмжээг 2026 онд” гэсний өмнө “ДНБ-нд эзлэх” гэж, “Дүгнэлт” хэсгийн “60.5 хувьтай” гэсний өмнө “2022 онд” гэж, “41.8 хувь” гэсний өмнө “2024 онд” гэж, “буурсан,” гэсний дараа “эдгээр онуудад” гэж тус тус нэмэх;

2.Тогтоолын төслийн хавсралтын 1.1 дэх хэсгийн “оршино” гэснийг “чиглэнэ” гэж, “Сангийн яам нь стратегийн баримт бичгийг” гэснийг “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичиг /цаашид “Стратегийн баримт бичиг” гэх/-ийг” гэж, 2.1 дэх хэсгийн “Цар тахлын” гэснийг “Ковид-19 цар тахал /цаашид “цар тахал” гэх/-ын” гэж, “2021 оноос 2024 оны хооронд нийт” гэснийг “2024 оны жилийн эцсийн байдлаар 2021 оны түвшнээс” гэж, “эзлэх хэмжээгээрээ” гэснийг “харьцуулсан харьцаа” гэж, 2.2 дахь хэсгийн “нэгжүүд” гэснийг “нэгж, байгууллагууд” гэж, 3.2 дахь хэсгийн “бүрдүүлэх” гэснийг “нэмэгдүүлэх” гэж, 3.5 дахь хэсгийн “зээлийн эх үүсвэрийг” гэснийг “зээлийг” гэж, 3.9 дэх хэсгийн “буцаан төлж” гэснийг

“бүрэн төлж” гэж, Хүснэгт 6-ын “өрийн зардал” гэснийг “өрийн багцын зардал” гэж, 5.4 дэх хэсгийн “буурах төсөөлөл” гэснийг “бууралт” гэж, Стратеги 4-ын “бүх хэсгийн хүрээнд” гэснийг “нийт хэмжээнд” гэж, 5.8 дахь хэсгийн “үнэт цаасны гаргалтыг” гэснийг “үнэт цаасны арилжааг” гэж, 6.1 дэх хэсгийн “Засгийн газрын өрийн харьцаа” гэснийг “уг харьцаа” гэж, “өрийн харьцааг” гэснийг “уг харьцааг” гэж, 6.2 дахь хэсгийн “хүрээний мэдэгдэлд” гэснийг “төсөөлөлд” гэж, “туссан дүнтэй” гэснийг “туссан хязгаарт” гэж тус тус өөрчлөх;

3.Тогтоолын төслийн 2.2 дахь хэсгийн “Голомт банкнаас” гэсний дараах “олон улсын зах зээлд” гэснийг, мөн хэсгийн “төрийн байгууллагуудын хувьд” гэснийг болон “гаргасан, мөн тус хугацаанд” гэснийг, 2.4 дэх хэсгийн “тогтмол” гэснийг, 3.1 дэх хэсгийн “хуульчлагдаж” гэснийг, 5.8 дахь хэсгийн “түлхүү” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 44

Бүгд: 96

54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн саналаа тайлбарлаж үг хэлэв.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бүс, орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга Л.Энхманлай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:48/

Уг асуудлыг 15 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг чөлөөлөх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:50/

Уг асуудлыг 15 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, мөн газрын дэд дарга Б.Батцэцэг, Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Салбарын бодлого, зохицуулалтын референт Б.Золбоо, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, мөн хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга С.Тайван, Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга, мөн сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн профессор Л.Бат-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн

зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Э.Бат-Амгалан, Ж.Баярмаа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:26/

Уг асуудлыг 16 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 26 минут үргэлжилж, 126 гишүүнээс 97 гишүүн хүрэлцэн ирж, 77.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. 65 гишүүн бүртгэгдэж 51.6 хувьтай байна. 2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр 9 асуудал хэлэлцэхээр байна. Байнгын хороо төсвийн хүрээ болон хөгжлийн төлөвлөгөө хэлэлцэж эцэслэн дуусаж амжихгүй байгаад байгаа учраас чуулганы хуралдаан үдээс хойш болж хойшилсон.

Одоо бас Эдийн засгийн байнгын хороон дээр 60 гаруй санал хураалт дутуу байна гэж байна. Тэрний хажуугаар зэрэгцээд төсвийн хүрээгээ болон бусад асуудлаа хэлэлцээд явж байя гэж бодож энэ чуулганаа эхлүүлж байна аа. Тэгээд энэ төсвийн хүрээ, хөгжлийн төлөвлөгөө өөрөө бас өргөн хүрээтэй асуудал болж байгаа учраас ирэх 7 хоногт ажлын 5 өдөр үндсэндээ чуулган бүтэн хуралдаж таарахаар болж байгаа. Энэ 2 асуудал маань хоёулаа 6 дугаар сарын 1-ний дотор батлагдах хуультай учраас бид энэ дээр асуудалдаа анхаарал хандуулж ажиллах шаардлагатай гэж ингэж бодож байна.

Би сая ажлын хэсгийн дарга Бадамсүрэн гишүүнтэй энд таарсан байгаа. Ер нь өнөөдөр уулзаад энэ Улсын Их Хурлын гишүүд энэ хөгжлийн төлөвлөгөөнд маш олон төрлийн саналууд гаргаж 140, 150 төрлийн санал хураалт явагдаж байгаа ийм нөхцөл дээр оччихсон байна. Тэгээд энэ чинь өөрөө нөгөө төсөвлөлт, төлөвлөлт, тайлагнал гэдэг 3 зүйл маань жил болгон хавар намрын хэрүүл болдог үндсэн сэдэв. Тэгээд ямар нэгэн тооцоо төлөвлөгөөгүй судалгаагүй саналуудыг олноор нь ажлын хэсэг дээр Улсын Их Хурлын гишүүд бусад Байнгын хороод дээр Улсын Их Хурлын гишүүд гаргаж тэгээд Эдийн засгийн байнгын хороо санал хурааж оруулж ирэх нь Улсын Их Хурлыг бол асуудлыг шийдэхэд ихээхэн хүндрэлтэй болох. Мэдээж зарчмын шаардлагатай зайлшгүй шаардлагатай зүйлсийг бид шийдээд явах нь зүйтэй. Зарим төрлийн хууль зөрчиж болзошгүй тийм зүйлүүд ажиглагдаж байгаа гэдгийг мэргэжлийн хүмүүс мэдээлэл ирүүлж байна лээ. Тэгэхээр энийг бид ирэх 7 хоногт ихээхэн сайн ярих нь байна.

Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хороо Сэддорж дарга энэн дээр анхаарч санал хураалтаа явуулахдаа хуулийн зөрчилтэй зүйлүүдээр санал хураахгүй байх дээр их сайн анхаарахгүй бол бид өнгөрсөн намар тэгсэн. Хуулийн зөрчилтэй асуудлуудыг чуулганы хуралдаан дээр оруулж ирж санал хураах нөхцөл үүссэн шүү дээ.

Тэгэхээр тиймэрхүү нөхцөлд оруулахгүйн тулд анхаарлаа хандуулаарай гэдгийг хэлье ээ. Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудлуудыг та бүхэндээ танилцуулъя.

Нэгдүгээрт, Монгол Улсын Засгийн газар, БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай.

Хоёрдугаарт, Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Гуравдугаарт, Эрхтэй, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болгон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газар өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Тавдугаарт, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Зургаадугаарт, СЕХ-ны гишүүнийг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Долоодугаарт, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Наймдугаарт, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Есдүгээрт, Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно уу.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудалтай холбоотой байхгүй шүү дээ. Горимын санал байж болно. Горимын саналаа? Тэмүүжин гишүүн горимын санал.

Х.Тэмүүжин: Юуны өмнө өнөөдрийн мэндийг хүргэе.

Улсын Их Хурлын дарга аа, Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд санаачилсан 2 хуулийн төсөл байгаа юм аа. Тэгээд танаас өргөн мэдүүлэхтэй холбоотой цагаа хүлээгээд суугаад байгаа юм. Тэгээд тэр 2 хуулийн төсөлтэй холбогдуулаад би нэг Үндсэн хуулийн 2, 3 заалтыг хэлмээр санагдаад байгаа юм. Үндсэн хуулийн 21 дүгээр зүйл дээр Улсын Их Хурал 1 танхимтай 126 гишүүнтэй байна гэсэн заалттай. Улсын Их Хурал үйл ажиллагаагаа чуулганы хэлбэрээр явуулна гэсэн заалттай. Тэгээд Улсын Их Хурлын нэгдсэн чуулган буюу өнөөдрийн энэ заалт Ерөнхий сайдад зориулсан тусгай суудалтай байх тухай Засгийн газарт тусгай эрх олгох тухай ямар ч зохицуулалт Үндсэн хууль дээр байхгүй. 126 гишүүнд зориулсан суудлын хуваарь 126 гишүүн хуралдаанаа хийхтэй холбогдуулсан чуулганы зохион байгуулалт. Энэ чуулганы зохион байгуулалтыг удирдахад хуралдааныг зохион байгуулахад чиг үүргийнхээ хувьд Улсын Их Хурлын дарга буюу спикер тусгайлсан суудалтай байхаас өөрөөр чуулганд хэн нэгэнд зориулсан тусгайчилсан суудал тэр

дундаа Улсын Их Хуралд ажлаа хариуцсан тайлагнадаг, Улсын Их Хурлаас томилогддог Улсын Их Хурал хариуцлага тооцдог албан тушаалтанд зориулж тусгай санал суудал байгуулахыг ерөөсөө зааж өгөөгүй.

Тийм учраас Үндсэн хуулийн энэ зохицуулалтыг амилуулах зорилготой хуулийн төсөл санаачлаад өргөн барих гээд бэлэн болчихсон. Нөгөөтээгүүр Засгийн газрыг магадгүй манай Ардын намынхан эрх баригчид тухайлсан хүнд зориулсан гэж хардаад байсан байж магадгүй. Оюун-Эрдэнэд ерөөсөө зориулаагүй. Энэ бол Засгийн газар Ерөнхий сайд эрх мэдэл хуваарилалтаар гүйцэтгэх эрх мэдэл Улсын Их Хурлын түвшинд ямар харьцаатай байх вэ гэдгийг л тодорхойлсон. Өнөөдөр Оюун-Эрдэнэ буучихсан. Дараагийн Ерөнхий сайд тодорхойгүй байгаа юм чинь энэ хэн нэгэнд зориулагдаагүй Үндсэн хуулийн зарчим барьж байгаа гэдэг агуулгаар нь өргөн баримаар байна аа. Энэ цаг хугацааны үед. Мөн дараагийн хууль нь.

Д.Амарбаясгалан: Таны горимын санал юу юм?

Х.Тэмүүжин: Би горим санал хэлэх гэж байна. Мөн дараагийн хууль нь болохоор өнөөдөр Улсын Их Хуралд байгаа намын төлөөллүүд гарын үсгээ зурчихсан. Ерөнхий сайдын мэдээллийн цаг гэдгийг Ерөнхий сайд өөрийнхөө ярихыг хүссэн зүйлээ ярьдаг биш Улсын Их Хурлын асуулгын цаг буюу Улсын Их Хурлын гишүүд цаг үе, нөхцөл байдалтайгаа холбоотой асуудлаар Засгийн газар Ерөнхий сайдад асуулт тавьдаг цаг болгож өөрчлөх. Ерөнхий сайд Засгийн газар гишүүд төрийн албан хаагчид Улсын Их Хуралд ирээд худлаа ярьдаггүй байхад зориулсан хуулийн төсөл байгаа юм аа. Энэ хуулийн төслүүдийг хүлээж аваач гэж хүсэж байна аа.

Энэ хуулийн төслүүд дээр 30 гишүүн гарын үсэг зурсан байгаа.

Д.Амарбаясгалан: Горимын санал гэсэн чинь харин завшуулчих шиг л боллоо доо Тэмүүжин гишүүнд. Харин тийм. Яг л Пүрэвдорж гишүүнээс сурсан ажил шиг болчихлоо. яах вэ х

Хуулийн төслүүдийг ер нь хүлээж авна авна. Тэмүүжин гишүүн мэдээж хуулийн төсөлтэй холбоотой өргөн барихаар бэлтгэл хангуулчихсан цаг, тов хүлээж байгаа төслүүд нэлээдгүй байгаа. Засгийн газраас ч тов хүлээж байгаа төслүүд байгаад байгаа. Тэгээд би яах вэ таны ярьсан энэ зарим зарчмын шинж чанартай зүйлийг парламентад суудалтай намууд хоорондоо ярилцаад ойлголцоод тэгээд улс төрийн өнцгөөр биш зарчмын байр сууриас асуудалд хандах нь зөв юм л гэсэн байр сууриар хандсан байгаа.

Тэгэхээр та хэд маань бүлгүүд хоорондоо энийг яриад заавал улс төрийн сэдэв агуулгаар нь биш парламентынхаа чанар чансааг сайжруулах, легитимыг дээшлүүлэх, асуулгын цагийг чанарыг сайжруулах гэдэг энэ агуулга зарчмыг бол бүрэн дэмжиж явах боломжтой л гэдэг байр сууриас хандаж байгаа. Тэгэхээр 2 бүлгийн даргатай уулзъя. Тэгээд хэрвээ зөвшилцөж ойлголцоод болж байгаа бол хамтдаа өргөн барьцгаагаад асуудлаа шийдээд явах ёстой байх гэж бодож байна аа.

Энхбаяр сайд ирчихсэн сууж байна уу? Хоёулаа ч нэг гурил татвартай холбоотой асуудалтай ярьж байгаа. Би хуулийн төсөл дэмжигдээгүйтэй холбоотойгоор Засгийн газар гишүүдийн хэлсэн саналуудыг тусгаад тодорхой

өөрчлөлтүүдийг оруулаад Гаалийн албан татвартай холбоотой хуулийн төслөө дахиж өргөн барь гээд санал хэлчихсэн байж байгаа. Мэдээж тариаланчид үр тариа тарихтай холбоотой, гурил будаа үйлдвэрлэлтэй холбоотой асуудал бол үүсэж байгааг бол ойлгож байгаа. Гэхдээ тодорхой хэмжээний зохицуулалт тохируулгыг зайлшгүй хийх шаардлагатай. Иргэд маань хямд бүтээгдэхүүнийг сонголтоор идэх эрх нь нээлттэй байх хэрэгтэй. Үйлдвэрлэл тариаланчид ямар нэгэн байдлаар бизнест эрсдэл учрахгүй байх нөхцөлийг хангах ёстой гэдэгтэй санал нэг байгаа.

Тэгэхээр Энхбаяр сайд энэ хуулийн төслөө яаралтай Засгийн газар шийдвэрээр яаралтай горимоор өргөн бариад орж ирж хэлэлцүүлэх нь зүйтэй шүү гэдгийг энэ ташрамд хэлчихье ээ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Байнгын хороо хуралдаж байгаа юм байна тэ? Тэгэхээр энэ соёрхон батлах асуудал чинь 64-өөр шийдэгдэх ёстой шүү дээ. Тэгэхээр шууд 2 дахь асуудлаасаа эхлээд явчихъя.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Одоо Байнгын хорооны саналаар Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна аа.

Санал хураалт

1.Байнгын хорооны саналаар Цусны донорын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт. 50 гишүүн буюу 64.1 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулах нь ээ.

Санал хураалт.

Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй. Тэгэхээр чинь энэ ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжихлээ гэсэн үг шүү дээ Улсын Их Хурал.

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

42 гишүүн буюу 53.8 хувиар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

4.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

5.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

67.5 хувиар санал дэмжигдлээ.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн.

Аан тийм Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжсэн байна.

Тэгэхээр 3 дахь санал хураалтаар дэмжээгүй санал гарсан учраас буцаалаа. Тиймээ.

Буцаах тогтоол баталсанд тооцогдоно.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдээ анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

14.14 цагт

Дараагийн асуудалд оръё. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байна.

Байнгын хорооны саналаар Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

67.9 хувиар хэлэлцэхийг дэмжлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

67.9 хувиар санал дэмжигдлээ.

3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

69 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг буцаах тогтоол батлан тооцсон тийм ээ.

4.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

75.3 хувиар санал дэмжигдлээ.

5.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

68.6 хувиар санал дэмжигдлээ. Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тогтоол баталсанд тооцлоо.

6.Донорын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Сүүлийн санал хураалт 69.8 хувь.

Эхнийхээ 1 дүгээр асуудал руу орьё 64-өөр соёрхон батлах асуудал байгаа.

/14.18 цагт/

Нэг дэх асуудал. Монгол Улсын Засгийн газар, БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцье.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байна.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газар, БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

Дэмжигдсэнгүй ээ. Хуулийн төслийг төсөл санаачлагчид буцаалаа. Би хэлж байгаад сануулж байгаад санал хураасан шүү.

/14.19 цагт/

Дараагийн асуудалд орьё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аубакир танилцуулна аа. Индэрт урьж байна.

Т.Аубакир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт мэдүүлсэн Засгийн газар өрийн удирдлагын 2026-аас 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж тогтоолын төслийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хууль тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгээс тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсэгт тусгагдсан давхардсан агуулга бүхий хэсгийг хасах, 2.7 дахь хэсгийн аймаг, нийслэл үнэт цаас гаргах эрхтэй болж санхүүгийн шинэ хэрэгсэл ашиглаж эхэлсэн хугацааг болон зарим бондын эргэн төлөгдөх хугацааг тодорхой болгож тусгах, 4.8 дахь хэсэгт тусгагдсан Засгийн газар дотоод үнэт цаасыг тогтмол арилжаалах төлөвлөгөөтэй байна гэснийг Засгийн газар дотоод үнэт цаасны арилжааг эхлүүлээд байна гэж өөрчлөхтэй холбогдсон зарчмын санал болон төслийн үг хэллэг, нэр томъёог жигдлэх техникийн засвар бүхий найруулгын саналыг санал тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн билээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газар өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан Сангийн сайд, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лангааны Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Цэвээндоржийн Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Лхагвасүрэнгийн Балчинлувсан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төслийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна аа. Нийт 16 гишүүний нэр ирсэн байна.

Дарааллын дагуу Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууна, алга байна, Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Бүсчилсэн хөгжлийн өргөтгөсөн зөвлөгөөнийг бүсүүдээр зохион байгуулаад нэлээд их зардал чирэгдэл гаргаад олон хүмүүсийг цуглуулаад ингээд ер нь сүүлийн үед бол энэ зөвлөгөөнүүдийг айхтар их хийж байна л даа. Тэгээд хамгийн гол нь үр дүн байх ёстой. Сая говийн бүсийн өргөтгөсөн зөвлөгөөнийг 5 сарын 12-нд Дорноговь аймагт хийсэн. Маш олон хүмүүс санал хэлсэн. Тэгээд энэ дээр гарсан, яригдсан асуудлууд, хөрөнгө оруулалтын асуудлууд ч яригдсан. Хууль эрх зүйн одоо шинэчлэлийн асуудлууд ч яригдсан.

Тухайлбал хөрөнгө оруулалтын маш олон асуудлуудыг яриад ингээд эрэмбэлсэн. Тэгээд энэ асуудлуудыг яаж хэрэгжүүлэх юм? Энэ Монгол Улсын энэ 26, 27, 28 оны энэ төсвийн хүрээний мэдэгдэл ирэх жилийн хийх энэ үйл ажиллагааны төлөвлөгөөнд энэ асуудлуудыг яаж эрэмбэлж тусгах юм бэ гэдэг дээр нэг мэдээлэл өгөөч ээ. Мөн энэ хууль эрх зүйн орчныг шинэчлэх ялангуяа энэ бүсчилсэн хөгжлийг цааш нь амилуулахад хууль эрх зүйн орчныг өөрчлөх шинэчлэх зайлшгүй шаардлагатай байгаад байгаа юм.

Тухайлбал энэ бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын хууль гээд 2003 онд батлагдсан хууль сайн хэрэгжиж чадаагүй өнөөдрийг хүрчихсэн. Тэгээд энэ хуулийг цааш нь амилуулах хэрэгжүүлэх бүсийн удирдлагыг их тодорхой болгох ёстой. Мөн бүсийн төсөв гэдэг зүйл зайлшгүй байхгүй бол хий хоосон баахан хийх ажлын мөрөөдлийн жагсаалт яриад тараад байдаг байж болохгүй.

Тийм учраас энэ нэгжийн хууль төсвийн хууль бусад хуулиуддаа энэ бүсчилсэн хөгжилтэй холбоотой олон зохицуулалтыг тусгаж өгөх ийм зайлшгүй шаардлагатай байгаа юм. Тэгээд энэ дээр хийхээр төлөвлөж байгаа зүйлүүд юу байна вэ гэсэн ийм асуудал байна.

Дараагийн дугаарт ер нь ирэх жилүүдэд бид төсвөө ингээд алдагдалгүй батлаад яваад байх юм уу, аль эсвэл тодорхой хэмжээгээр төсвөө алдагдалтай батлаад тэгээд энэ 14 мега төсөл тэгээд энэ бүсүүдээс гарсан саналууд, энэ хөрөнгө оруулалтынхаа ажлуудыг цаашдаа хийх юм уу?

Хоёрт гэвэл энэ гадаадын зээл тусламжуудаа яаж ашиглах юм бэ? Энэ чинь одоо гаднын зээл тусламжаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа зөрчиж болохгүй гээд ашиглаж болохгүй болчихсон. Төсвөө алдагдалгүй болгоно гээд ингээд шахаад баталчихсан. Тэгээд энэ чинь юм хийх боломж байгаа юм уу үгүй юм уу? Яаж цаашаагаа одоо бид энэ өмнөө тавьсан ажлууд хүн бүхэн л ярьж байна шүү дээ. Энэ 14 мега төслөө цааш нь явуулна, үргэлжлүүлнэ зогсохгүй гээд. Тэгээд энэ төсөв энэ талаасаа хууль талаасаа харах юм бол энэ чинь явмааргүй шинжтэй байх юм. Тэгээд эд нар дээр ямар бодлого байгаа юм?

Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодруулж асууя.

Дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгөхөөс өмнө Пүрэвдорж дэд дарга горимын санал хэлье гэж байна.

Б.Пүрэвдорж: Ингээд энэ чинь төсвийн төсөөлөл явж байна. Ирэх оны төсвөө яаж бид нар зарцуулах вэ? Яаж ажлаа хийх вэ? Энэнийхээ дагуу бид нар энэ Засгийн газар 10 сарын 2 хүртэл төсвөө тодорхой хэмжээнд багцлаад оруулж ирэх ёстой. Тэгээд энэ дээр Их Хурлын гишүүд яг тэр орон нутагтаа ажиллаж байгаа тэр дүүрэгтээ ажиллаж байгаа тэр Их Хурлын гишүүд өөрсдөдөө тулгамдаж байгаа тэр асуудал болон улс орны нийгмийн асуудлыг бүгдийг нь эдийн засгийн асуудлыг бүгдийг нь шийдвэрлэх ийм асуудал хэлэлцэгдэж байна. Гэтэл Ерөнхий сайд алга байна. Тэргүүн шадар сайд алга байна. Шадар сайд алга байна. Бас нэг Шадар сайд алга байна. Энэ танхимд ерөөсөө гуравхан Ардын намын сайд, дээрээс нь АН-ын Алтангэрэл, Эрдэнэбүрэн, Батсуурь 3 сууж байна. Номин сайд байна. Ингээд долоохон сайд байна.

Тийм учраас яг энэ одоо хэлэлцүүлэг бол үр дүнтэй болж чадахгүй ээ. Энэ Их Хурлын гишүүдийн хүссэн тэр асуултад хариулж чадахгүй. Бид нар энэ засаг төр янз янзын юм болж байгаа байх. МАН Бага хурлаараа асуудал шийдсэн байх. Тэгээд энэ чинь бол намын чинь л асуудал. Өнөөдөр засаг бол хэвийн үргэлжлээд явж байгаа. Их Хурлаар засаг огцрох тухай асуудал орж ирээгүй. Ерөнхий сайд огцрох тухай асуудал орж ирээгүй.

Тийм учраас энэ хэлэлцүүлэг бол маш үр дүнгүй болох юм байна аа. Тийм учраас энэ хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргаж байна. Санал хураалгаж өгнө үү?

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Энэ санал хураалт хүчингүй шүү. Хэлэлцэх асуудалтай холбоотой хойшлуулах санал Дэгийн тухай хуулиараа өмнөх өдрийн 16 цагаас өмнө бичгээр санал ирүүлэх дэгтэй юм байна Пүүжээ дарга.

Хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулах санал. Тэгээд Пүүжээ дарга санал дэмжигдсэнгүй. 15 хувиар горимын санал дэмжигдсэнгүй.

Асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан. Нанзадын Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Төсвийн хүрээний мэдэгдлийг бид нар эхний хэлэлцүүлэг дээр энэ талаар нэлээн дэлгэрэнгүй ярилцсан. Манай Тэргүүн шадар сайд Эдийн засаг, хөгжлийн сайд маань энэ дээр маш тодорхой хариултууд өгсөн байгаа шүү. Ирэх жилийн

төсөв бол ерөнхийдөө 2025 оны тоон дээр багтаж орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл ямар нэг зардлын өсөлт байхгүй, орлогын хувьд ч гэсэндээ ер нь өсөлт байхгүй ингэж орж ирж байгаа. Ер нь жил бүр 5-аас 8 хувийн механик өсөлт байдаг. Хүн амын өсөлт, хуультай маш олон зардлууд дээр ийм өсөлт гардаг.

Дээрээс нь маш олон төсөл, хөтөлбөрүүд үндэсний хэмжээний хөтөлбөрүүд гээд ингээд өсдөг. Гэсэн хэдий ч энэ жилийн зардлын дээд хязгаарт орж ирж байгаа. Дээрээс нь бид ирэх жилүүдээс татварын реформ хэд хэдэн мөн үндэсний хэмжээний ийм хөтөлбөрүүдтэй, холбоотойгоор төсөв, төсвийн зардал дээр нэлээн хумилт хийх ийм шаардлага зорилт бий болж байгаа.

Тийм учраас яг таны хэлсэнтэй ижил би зүйл хэлье. Ер нь хөрөнгө оруулалтын орон зайнууд нэлээн хумигдана. Өөрөөр хэлбэл төсөв дээрээс шүү.

Тийм учраас төр, хувийн хэвшлийн түншлэл, гаднын хөрөнгө оруулалт, гадаад дотоодын төр, хувийн хэвшлийн түншлэл мөн баялгийн солилцоо ч гэж яригдаж байгаа маш олон ийм эрх зүйн орчнуудыг бий болгож чадаж байж бид энэ олон бүтээн байгуулалтуудыг хийж чадна.

Дээрээс нь мөн одоо эдийн засаг, нийгмийн хувьд бид дотоодоос биш гадаад хүчин зүйлээс шалтгаалж байгаа энэ сорилтын үед аль болох төсөв дээр ачаалал авахгүйгээр төсвийн хөрөнгө оруулалт болон ийм импортыг дэмждэг ийм зүйлүүдээсээ аль болох татгалзаж өөр хувилбарууд дээр бид хөрөнгө оруулалтуудаа ачааллаа өгч явах нь дараагийн ойрын жилүүдийн ийм бидний зорилт байх болно оо.

Тийм учраас төсвийн хүрээний мэдэгдэл дараа жилийн төсөөллүүд ерөөсөө нэг аравхан л тоо байгаа. Маш ойлгомжтой ийм 10-нд тоо байгаа. Тэгэхээр одоо гол өөрчлөлт бол ер нь хөрөнгө оруулалт дээр л явна. Өөрөөр хэлбэл төсөв дагасан төсвийн хөрөнгө оруулалтууд ирэх жилийн төсөв дээр ер нь багагүй хумигдана гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Наранбаатар гишүүн тодруулж асууя.

Н.Наранбаатар: Бүсчилсэн хөгжлийг ирэх жилүүдэд амилуулах Улаанбаатар хотын энэ төвлөрлийг сааруулах, утааг бууруулах чиглэлээр ямар ажлууд хийх юм. Саяын энэ бүсийн зөвлөгөөнүүдийн ач холбогдол нь юу байгаа юм. Бүсийн зөвлөгөөнүүдээс ярьсан хөрөнгө оруулалтын асуудал, хууль, эрх зүйн орчны шинэчлэл гээд ямар ажлуудыг энэ бүсүүд рүү ирэх жил хийх юм бэ. Саяын эрэмбэлээд байсан ажлууд ирэх жил хийгдэх юм уу, үгүй юм уу гээд ийм тодорхой асуулт асуусан.

Тодруулъя. Тодруулга авъя.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Наранбаатар гишүүнээ одоо бид нар чинь төсвийн хүрээ ярьж байгаа шүү дээ. 10 тоо л ярьж байгаа. Орлогын доод түвшин, зардлын дээд хязгаар, эдийн засгийн өсөлт, үнийн өсөлт, хөрөнгө оруулалтын хязгаар, Засгийн газар өрийн дээд хязгаар гээд. Энэ асуудлуудын хүрээнд бол тоонууд маш ойлгомжтой

байгаа гэж би бодож байна. Саяын таны асуулт бол ирэх оны төсөв орж ирэх үед илүү их тодорхой яригдах учиртай.

Дээрээс нь одоо хөгжлийн төлөвлөгөө яригдаж байгаа. Хөгжлийн төлөвлөгөөн дээр бол зорилтот түвшнүүдээ тавьсан ийм хэмжээнд байгаа. Ер нь яах вэ зүгээр тоймлоод хэлэхэд томоохон бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлууд бол и энэ он болон 2026 онууд дээр нэлээн бид эрэмбэлнэ ээ. Тэгэхээс ч өөр аргагүй болж ирж байна. Бид 14 мега төслөөс ямар ч тохиолдолд татгалзаж болохгүй. Яах вэ цаг хугацааны хувьд биднээс шалтгаалахгүй энэ хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал ийм зүйлээс шалтгаалж бид эрэмбэд оруулж болно.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Төсвийн хүрээ гэдэг өөрөө их чухал баримт бичиг ээ. Бид нар энийг чухал баримт бичигт чухал бишээр хандаж ирсэн туршлагууд түүхүүд их байдаг. Жилдээ 3, 4 өөрчилдөг. Тэгээд өнгөрсөн жилээс эхлээд алдагдалгүй төсөв гэдэг ойлголт энэ зарчмын ойлголт гарч ирээд ингээд явж байгаа. Тэгээд яг үнэндээ бид нар алдагдалгүй л төсөв гэж хэлээд байгаа болохоос биш 2025 оны төсөв маань ер нь алдагдалгүй төсөв баталсан юм уу гэдэг дээр би арай өөр байр суурьтай байдаг. Би хоёрхон тоо хэлчихье. Монголбанкн дээр байгаа Монголбанкн дээр алдагдал нэрээр бичигдчихсэн байгаа 7 их наяд төгрөг байгаа. Энэний чинь бараг дийлэнх нь 4.5, 5 их наяд нь байна уу. Орон сууцын санхүүжилтийн ипотекийн хөтөлбөр тэнд явж байгаа. Энэ чинь өөрөө Монгол Улсын төсвийн зарлагад бичигдээд зарлага хэсэгт бичигдэж байх ёстой мөнгө. Хоёрхон тоог хэлчихье.

Дараагийнх нь Ирээдүйн өв санд АМНАТ-ийн төлбөрөөс орох ёстой 65 хувийн төлбөр 20 хувь, 40 хувь гээд дураараа хасаад явчихсан. Эндээс 1 их наяд 2 их наядын асуудал явж байгаа. Ингээд үзэхээр багадаа 30 гаран их наядын төсвийн зарлагын чинь бараг дэгсдүүлээд, өсгөөд хэлбэл хориод хувийг нь ийм хуримтлагдсан алдагдал тэнд явж л байгаа. Тэгэхээр бид нар яг үнэндээ бол бид нар гоё сайхан алдагдалгүй төсөв гэж хэлж байгаа болохоос биш алдагдалгүй төсөв бид нар ерөөсөө батлаагүй.

Асар өндөр бодит яг бодит тоо баримт бол алдагдалтай ийм л төсөв явж байгаа 1 дүгээрт.

Хоёрдугаарт нь төсөв ийм алдагдалгүй нэртэй алдагдалтай төсөв бид нар батлаад л явж байгаа.

Хоёрдугаарт нь дахиад сүүлийн үед гарч байгаа тэр бартер гээд төсвийн гадуур зүйл, алдагдлыг бол үндсэнд нь нуун дарагдуулж явах гэж байгаа л зүйл шүү дээ. Дахиад тэр зарим зээлүүдийг төсвийн зарлага тооцохгүй байх тухай нэгэнт л угаасаа л тэр чинь төсвөөс төлбөр нь гарах гэж байгаа тоо бүхэн л төсөв дээрээ л амрах л ёстой шүү дээ. Тэгэхээр 1 ийм зарчмын зүйлсүүд энэний цаана ингээд яваад байна. Тэгээд ер нь цаашдаа энэ яг одоо тэр бид нар энэ алдагдалгүй төсөвтэй гэдэг энэ үг хэллэг байр суурь дээрээ ямар бодолтой байдаг юм? Цаашдаа яг үнэхээр алдагдалгүй гэвэл алдагдалгүй төсөв гэж байгаа бол үнэхээр зарчмаар нь алдагдалгүй төсөв л бид нарт хэрэгтэй. Аль эсвэл алдагдалтай төсөв гэж байгаа бол заавал бие биеэ ингэж хуурах бол шаардлагагүй. Тэгвэл алдагдалтай төсөв саяын тоонуудыг үнэн зөвөөр нь гаргаж тавих санхүүгийн харьцаагаа барих тэгэхдээ

энэ бол хэрэгцээ шаардлагын үүднээс тэр бартер 9 жорын тэр хууль, дүрэм журам, санхүүгийн тогтолцоогоо эвдэж байхын оронд шаардлагатай бол энэ тоо баримтуудыг үнэнээр нь бичих, шаардлагатай бол алдагдалтайгаараа бичих. Нэгэнт ингэж бие биеэ хууран мэхлэх биш зарчимтай юм зарчмынхаа дагуу явах гэдэг би бол ийм хувийн зарчмын байр суурьтай байдаг.

Энэн дээр нэг албан ёсны хариулт, тоо баримт, байр суурь өгөөч?

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Эдийн засгийн хөгжлийн яамнаас нэмж хариулаарай.

Цогтгэрэл дарга ер нь төсвийн хүрээ өмнө яригдах үе болгонд энэ нэг асуулт асуудаг юм. Хэрвээ та баталсан төсөвтөө итгэлгүй байгаа бол энэ төсөв батлах хэрэг байна уу? Төсвийнхөө зардлыг бид байнга бууруулах хэрэгтэй, алдагдалгүй байх хэрэгтэй гээд та өөрөө ингээд ийм зарчмын шаардлага тавьж байсан. Энэтэй бид санал нийлсэн. Ингээд төсөв баталсан.

Тэгсэн мөртөө одоо бид Их Хурал дээр мөн баталсан 14 мега төслүүд маань ер нь бараг зуугаад их наядын ийм зүгээр урьдчилсан байдлаар мөн л төсөв гарч байна. Төсвөө алдагдалгүй батлаад зардлаа жил бүргэн бууруулах ёстой тэгсэн мөртөө энэ том бүтээн байгуулалтыг таны хэлж байгаагаар төсөвтөө багтаа гэж байна. Тэгэхээр яаж багтаах вэ? Танд шийдэл байна уу? Та хууль санаачлах, хууль батлах бүрэн эрхтэй.

Тэгвэл тэр шийдлээ оруулж ирээд хэдүүлээ энд ярилцаад, батлаад, тэгээд тэрүүгээр чинь явъя л даа, болно шүү дээ. Яагаад болохгүй гэж? Бид аль болох төсөв дээрээ төрийн үйл ажиллагаа зайлшгүй төрөөс санхүүжүүлэх ёстой тэр зүйлүүдээ л авч явъя. Бүтээн байгуулалт болон хувийн хэвшлээр хийлгэж болох зүйлийг төсөв дээрээ санхүүжүүлдгээ больё гэдэг ийм зарчим руугаа л бид явж байгаа. Ийм тохиолдолд бид олон улсад хэрэглэгддэг практик туршлага, хууль эрх зүйн орчныг нутагшуулах хэрэгтэй. Төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалт.

Одоо өөр юу байж болох вэ? Баялгийн солилцоо. Энэ бол Ойрх Дорнодын бүхий л улсууд байгалийн баялагтай бүхий л улсуудын туулж өнгөрүүлж байгаа сайн туршлагууд. Энийг яагаад бид хэрэглэж болохгүй гэж. Олон улс хэрэглэж болоод байна, хөгжөөд байна. Ард түмэн сэтгэл хангалуун амьдарч болж байна. Тэрийг энд бид улс төржүүлээд нэг жижигхэн эрх ашгаар бие биеийгээ тонгоруулж унагаагаад ингээд байх юм бол дахиад л 10 жил, дахиад л 20 жил гацна.

Д.Амарбаясгалан: Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

Энэ манай энэ олон сонгогдсон гишүүд хаашаагаа гүйлдээд байх шиг байна. Энэ танхим тогтвортой суухгүй болчихсон байх чинь.

Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Жавхлан сайд уг нь би тэр гарц гаргалгааны тухай л ярьсан юм л даа. Алдагдалгүй гээд ингээд биеэ хуураад саяын тэр тоо баримтууд дээр та бас хэлээрэй. Төсвөөс санхүүжигдэх ёстой ипотека, АМНАТ-ийн төлбөрийн хувь,

процент гээд олон олон зүйлүүд үндсэндээ бид нар энийг төсвөөс гадуур байгаа, төсвийн зарлага тооцохгүй байгаа. Алдагдалгүй гэж байгаа мөртөө алдагдалтай төсөв баталчхаад л сууж байгаа шүү. Бид нарын тэр алдагдал чинь нууц хэлбэрт л оруулчхаад байгаа шүү дээ. Харин бүүр ингэж нууц нуугдмал хэлбэрт төсвөө алдагдалгүй гээд алдагдалтай батлаад ингэж дахиад дээрээс нь бартер гэж байхын оронд бүүр шаардлагатай бол энэ нөхцөл байдлаа үнэлээд яг ингэсэнд орвол энэнд орвол алдагдалтай нь дээр шүү. Яг ингэж явсанд орвол алдагдалтай нь дээр шүү. Ингэж бие биеэ үндсэндээ хууран мэхэлж ингэж явсанд дор бол.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүнээ одоо эргэж буцаад хэрэггүй ээ. Бид 4 жилийнхээ гараан дээр алдагдалгүй төсөвтэй хэдэн жил яваад үзье гээд бүгдээрээ шийдчихсэн. Одоо эндээсээ буцаад хэрэггүй. Дахиж бие биедээ ингэж даалгавар өгөөд ч хэрэггүй. Эндээ итгэл үнэмшилтэй байх хэрэгтэй. Монголбанкны баланст итгэхгүй байгаа бол Монголбанкныхнаас энд авчирч суулгаж байгаад асуух хэрэгтэй. Тэр алдагдал нь ямар юм гээд.

Монголбанкны алдагдал гэхээс илүү ер нь миний мэдэж байгаагаар тэнд бодлогын зардал л байдаг юм даа. Бодлогын зардал л байдаг юм. Бодлогын хүүгийн энэ зардал байна, ипотека ч гэсэн бодлого гэж би харж байгаа. Тэрийг өнгөрсөн жилүүдэд та өөрөө ч гэсэн энд сууж байхдаа шийдсэн л асуудлууд. Тэрийг тусад нь ярина биз дээ. Одоо энэ дээр төсвийн хүрээ ярьж байна. Энэ дээр бие биеийнхээ цагийг авч өөр тийшээ давхилдаад яах вэ.

Төсвийн хүрээгээ хугацаанд нь энэ чинь 6 сарын 1-ээс өмнө батлах ёстой хуулийн хугацаатай ийм зүйл.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн алга байна. Баясгалан гишүүн мөн үү? Мөн байна. Асуулт асууя.

Ж.Баясгалан: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд инфляцыг 2026 онд 7 хувь, 2027 онд 6.4 хувь, 2028 онд 6 хувьд хүрэхээр төсөөлсөн байгаа.

Харин Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс инфляцыг 2026 онд дунджаар 8.2 хувь, 2027 онд 7.2 хувь, 2028 онд 6.8 хувь байх төсөөллийг гаргасан байна аа.

Одоогийн байдлаар бол 2024 оны төгсгөлд инфляц 9.2 байсан бол одоо 2025 оны 4 дүгээр сарын байдлаар 8.6-тай байгаа. Тэгээд Засгийн газар инфляцыг хүнсний хувьсгал хөдөлгөөн, Атрын-4, тариалангийн тогтвортой хөгжлийн аян зэрэг эрчимжүүлсэн МАА-г хөгжүүлэх дотоодын хүнсний үйлдвэрлэлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн дүнд хүнсний үнэ саарч инфляцын дарамт буурахаар тооцсон байна аа.

Мөн гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх төсвийн алдагдлыг хязгаарлахад чиглэсэн бодлогын нөлөөгөөр инфляцыг үргэлжлүүлэн буулгахаар төлөвлөжээ. Тэгэхээр энэтэй холбогдуулаад 2 асуулт асууя. Инфляцын түвшнийг тооцож гаргахдаа төсөв төрийн тогтвортой байдлын зөвлөлийн түрүүчийн зөрүүтэй байсан гаргасан инфляцын төсөөллийг хэрхэн харгалзаж үзсэн бэ? 1 дүгээрт.

Хоёрдугаарт 2025 онд манай улс 83 сая тонн нүүрс экспортолж, дунджаар 105 ам.доллар-оор тооцоолсон. Тэгэхэд одоо бол үнэ унасан экспорт саарсан. Дэлхийн зах зээл дээр одоогийн байдлаар 97 ам.доллар байгаа. Тэгэхээр энэ үзүүлэлт буурсан байна аа. Монголбанкны зүгээс Хятадын эдийн засаг ирэх жилүүдэд саарахтай холбоотойгоор нүүрсний үнэ 2026 он хүртэл унана гэсэн тийм мэдээлэлтэй байгаа юм.

2023 онд 117 байсан юм шүү дээ нүүрсний үнэ. Тэгэхэд одоо 2024 онд 101, 2025 онд 80 гээд, 2026 онд 75 орчим байна гэсэн тийм таамаг байгаа юм. Нүүрсний үнэ буурч байгаатай холбоотой гадаад валютын нөөцийн хэмжээнд нөлөөлж улмаар инфляц төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй болох эрсдэлийг ер нь тооцсон уу.

Энэ дээр ямар бодолтой байгаа вэ? Ямар тооцоо байгаа вэ гээд энэ 2 асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Нэмж хариулт өгөх албан хаагч нар шууд.

Б.Жавхлан: Асуултад хариулъя. Өнөөдөр бид нар төсвийн хүрээ ярьж байгаа шүү. Төсвийн хүрээ гэдэг бол энэ ер нь онолын ийм матриц байдаг. Ер нь төсөв макро төсөөллүүдийн маань хязгаар тоонууд л байгаа. Энүүний ардаас бид төсөв оруулж ирнэ. Төсөв дээр илүү их таны асуултууд дээр тодорхой хариулагдана. Энийг Эдийн засгийн хөгжлийн яамнаас манай энэ Хүрээг оруулж ирдэг юм байгаа юм. Эдийн засгийн хөгжлийн яамныхан нэмж хариулна биз. Би яг өөрийнхөө мэдлэгийн хүрээнд хариулъя.

Баясгалан гишүүний асуусан тэр үнийн өсөлт инфляц бол энэ чинь зорилтот түвшин юм байгаа юм. Бид нар энэ түвшин рүү инфляцыг чиглүүлнэ. Тийм учраас бусад бодлогын зорилтууд маань, бодлогын хэрэгслүүд маань энэ рүүгээ чиглэнэ гэж байгаа зорилтот түвшнээ хэлж байгаа юм. Ямар гарах нь гүйцэтгэл тусдаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бол ингээд саналууд тоонууд авдаг. Энэ тоонуудын яг гол энэ жилийн түвшнүүд хоорондоо зөрж байгаа. Тэгэхдээ би Засгийн газрын оруулж ирж байгаа тоонуудаа би хамгаална. Зардлын хязгаар төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс доогуур байгаа. Өөрөөр хэлбэл хэмнэлттэй гэсэн үг. Орлого дээр ч гэсэн нэлээн болгоомжтой доогуур байгаа. Инфляцын түвшин ч гэсэн доогуур байгаа.

Бидний оруулж ирсэн инфляцын доогуур түвшин бол Төв банкныхтай харин ойролцоо байгаа. Төв банкных чинь 5 дээр нэмэх, хасах 2 гэж байгаа. Өөрөөр хэлбэл 3-аас 7 гэсэн ийм депозон дотор үнийн өсөлт ирэх жилүүдэд хадгална гэдэг бодлогын зорилтоо тавьчихсан.

Ингээд энүүний хойноос мөнгөний бодлого нь хатуурах нь уу, зөөлөн байх нь уу? Төв банк өөрөө шийдвэрээ гаргаад тухайн үедээ ингээд явах нь гэсэн үг. Тийм ч учраас Засгийн газар хувьд бол Монголбанкны энэ оруулж ирж байгаа зорилтот энэ депозон дотор бол байж байгаа гэж ингэж харж байгаа. Энэ рүүгээ бид нар Төв банкны мөнгөний бодлоготой уялдуулаад ингээд хөрөнгө оруулалт, мөн төсвийн зардал болон бусад зээл тусламжийн ашиглалт гээд энэ бүх юмаа алхмаа тааруулаад тунг нь тааруулаад явна гэсэн үг.

Тийм тэгээд гүйцэтгэл бол биш шүү. Инфляц ямар түвшинд яаж зөрж гарах нь вэ? Энэ хүрээндээ байх нь вэ? Гүйцэтгэл ямар байх нь вэ? Энийг бол тухайн үеийн явцад нь эсвэл гүйцэтгэл дээр нь ярих нь илүү оновчтой. Тийм Эдийн засгийн хөгжлийн яамнаас нэмэх зүйлүүд байвал хэлээрэй.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индэр.

И.Батхүү: Эдийн засаг хөгжлийн яамны ТНБД Батхүү. Баясгалан гишүүний асуултад хариулъя.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ирүүлсэн тоо манай яамнаас гаргасан тооцооллын зөрөө нь гол зөрөө нь сая төсвийн зарлагын хэмжээн дээр байгаа. 2 их наяд орчмын 2026 онд илүү зардлын энэ зардал өндөр байна гэдэг нь өөрөө цаанаа инфляцын тооцоолол дээр өдөөгч хүчин зүйл болж байгаа. Ер нь бол эдийн засгийн тэлэлттэй халалттай үед төсвийн бодлогоор агшаах бодлого төсөв эдийн засаг агшсан үед нь төсвөө тэлэх бодлогоор эдийн засгийн өсөлтийг тогтвортой авч явах нь давхар утгаараа инфляцыг тогтвортой түвшинд нөлөөтэй байдаг. Тэгээд инфляцыг бол зөвхөн Засгийн газар төсвийн бодлого хадгалахад биш Монголбанкны мөнгөний бодлоготой хослуулж, уялдуулах замаар явах ёстой. Тэгээд Монголбанк өөрсдөө зарласан тэр зорилтот инфляцын түвшин бас сая Сангийн сайд хэлсэн бууруулах түвшинд авч явж байгаа. Тэр нүүрсний үнийн хувьд бол бид нар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн үнэ дунд хугацаандаа өсөх төсөөлөлтэй. Манай гаргасан.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

И.Батхүү: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн нүүрсний үнийн дунд хугацааны төсөөлөл нь бол манай гаргасан тооцооллоос өндөр байгаа. Бид нарын хувьд бол эдийн засгийн үүсээд байгаа нөхцөл байдал ирэх 2 жил дамнаж гарах нөлөөллийг харгалзаад илүү болгоомжтой байдлаар үнээ төсөөлж оруулсан байгаа.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Бид өнөөдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байна аа.

Өөрөөр хэлбэл 2026, 2027, 2028 онуудад Улсын эдийн засаг, санхүүгийн байдал, нөхцөл байдал ямар байх вэ ард иргэдийн амьдралд хэр наалдах вэ гэсэн төсөөллөө хэлэлцэж байна аа.

Тийм учраас ард түмний ахуй амьдралтай холбоотой асуултыг ард түмэнд ойлгомжтой энгийн үгээр асууя. Энгийн үгээр хариулж өгөөрэй гэдгийг хүсмээр байна.

Нэгдүгээрт, ирэх онуудад ард түмний нуруун дээр дарамт болж байгаа татварууд болох ААНОАТ, ХХОАТ, нэмэгдсэн өртгийн албан татваруудыг яаж бууруулахаар тооцож байгаа вэ? Сонгуульд өрсөлдөх болохоороо бүгдээрээ татвар бууруулна татвар бууруулна гэж бүгдээрээ ам амандаа шаагддаг хэдий ч яг энэ төсөөлөл дээр чинь татвар бууж байгаа юм бол харагдахгүй байна, 1 дүгээрт.

Хоёрдугаарт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өсөлт буюу инфляцын түвшин 8.2 хувьтай байхаар тооцсон байхад 7 хувьтай байна гээд оруулаад ирсэн байна. Гэтэл гэтэл бодит байдал дээр инфляц маш их өсөж байгаа шүү дээ. 8-аас 9 жилийн өмнө МАН-ынхан доллар 1700 төгрөг боллоо гээд 17 боодол нэгтийн дэвсгэрт бариад орилцгоогоод байсан шүү дээ. Гэтэл өнөөдөр долларын ханш 3600 төгрөг болчихсон энэ зун, өвөл, хавар, намар доллар дахиад яаж нэмэгдэхийг би мэдэхгүй байна. Та нарт мэдэж байгаа юм байна уу гэж асуумаар байна.

Гуравдугаарт, төрийн албан хаагчдын цалин, өндөр насны тэтгэвэр, бусад тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ л гээд байнга лоозогносон маягтай ярьдаг болсон. Энэ нь нэг шавхруу дусааж байгаа юм шиг 6, долоохон хувь л нэмэх юм байна. Ер нь энэ төрийн албан хаагч, ахмадын тэтгэврийг, цалин тэтгэврийг. Тэгэхээр энэ эмч, багш, тийм ээ, үйлчилгээний жирийн албан хаагчдынхаа ахуй амьдрал ямар байгааг дарга сайд нар маань та нар ер нь мэдэж байна уу? Олон жил ингэж явсан. Ойлгох болоогүй юу? Хэзээ энэ ард иргэдийнхээ гар дээр нэг хүн шиг амьдрах цалинг тавьдаг болох юм бэ? Энийг нэг тодорхой хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя.

Дахиад л хэлье дээ. Бид төсвийн хүрээ ярьж байна шүү. Төсөв яриагүй. Энэ чинь аравхан тоо л ярьж байгаа. Төсвийн чинь зардлынх чинь дээд хязгаар орлогын доод түвшин гээд таны саяын ярьсан зүйлтэй холбоотой ийм 2 дээд доод 2 хязгаар л ярьж байгаа. Таны яригдаж байгаа асуудал бол төсөв өргөн баригдах үед илүү их тодорхой болж ирнэ. Нэг тал та нэг талаараа татвараа бууруул гэж ярьж байна. Нөгөө талаараа зардлаа нэмж болохгүй шүү гэдэг. Тэгээд энэ хайчин дотор л энэ төсвийн хүрээ, төсөв 2 маань орж ирнэ.

Хоёр талаасаа хязгаартай. Та багш нарын цалинг нэмэхийн тулд бид төсвийн орлогоо нэмэх хэрэгтэй. Татвараа бууруулж байгаад л нэмнэ дээ. Тэгэхээр яаж явж таарах вэ. Та энийг өөрөө нэг бодоорой. Дахиад хэлье энэ удаа төсөв яриагүй бид төсвийн хүрээ ярьж байгаа. Эдийн засгийн хөгжлийн яамнаас орж ирсэн энэ Засгийн газраас орж ирсэн манай энэ төсвийн хүрээг ярьж байгаа гэж ойлгоорой. Яах вэ гэхдээ бид Аж ахуй нэгжийн орлогын албан татвар, ХХОАТ, нэмэгдсэн өртгийн албан татвар, Татварын ерөнхий суурь хуульдаа бид өөрчлөлт оруулахаар бэлдсэн байгаа. Ер нь хангалттай хэлэлцүүлэг хийсэн. Энэ удаагийн онцлог гэх юм бол харин Их Хуралтайгаа бид нар хамтарч төслүүдээ боловсруулж ажлын хэсэг хамтарч ажиллаж байгаа ирэх 7 хоногт ер нь өргөн барина гэсэн ийм ажлын төлөвлөгөөтэй явж байна. Тэр үед илүү их тодорхой ярина биз.

Цалин дээр бол харин би Мөнхтуяа гишүүн тантай санал нийлэхгүй байна шүү. Хамаагүй ингэж хийрхэж болохгүй. Сүүлийн жилүүдэд бас бид ер нь төрийн албан хаагч нарын цалинг нэмэх ялангуяа сүүлийн жилүүдэд энэ өссөн үнийн өсөлт инфляцтай уялдуулж нэмэхийн тулд энэ төсвийн бүх боломжуудыг тийш нь чиглүүлсэн. 6, 7 хувь биш шүү. 30-аас 40 хувь нэмэгдсэн байгаа төрийн албан хаагч нарын яг гар дээрээ авч байгаа цалин. 30-аас 40 хувь нэмэгдсэн сүүлийн 3 жилийн дотор. Цаашдаа яаж нэмэгдэх вэ гэдэг чинь өөрөө хуультай. Та өөрөө хуулийг нь

батлалцсан. Үнийн өсөлттэй уялдуулж гэж байгаа. Үнийн өсөлтийг бол төв банк гаргадаг. Статистикийн ерөнхий газраас гаргадаг. Тэр хүрээнд нэмээд явах ийм л зардлаа ирэх оны төсөв дээр багтааж орж ирнэ. Энэ удаагийн төсвийн хүрээн дээр бол энэ тоо байхгүй. Энэ төсвийн хүрээ бол тийм тоо харуулдаг ийм хууль биш.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Энхтуяа: Ер нь бол дандаа байхгүй, болохгүй бүтэхгүй гэдэг үгээр ингэж ам хаадгаа болимоор байна. Тэгвэл хэзээ хийдэг болох юм. Бид нар сонгууль болонгуут бүгдээрээ чадна хийнэ гээд ордог шүү дээ. Тэгээд л болохгүй бүтэхгүй байхгүй гээд тэгсэн мөртөө маш их төсөв үргүй зарж байгаа шүү дээ. Энийгээ хумьж болдоггүй юм уу? Ер нь ард иргэдийн амьдрал хүнд байгаа шүү дээ. Болохгүй юмыг ярьж байгаа болохоос би хийрхээд байгаа юм бол байхгүй. Яг бодит байдал дээр ямар ч байсан энэ багш нарын нийгмийн асуудал маш хүнд байгаа. Багш гээд ч байх юмгүй эмч тийм жирийн иргэдийн амьдрал хүнд байгаа гэдгийг та бүхэн өөрсдөө мэдэж байгаа байх гэж найдаж байна.

Сонгуулиар бол болно чадна гэдэг сонгууль дуусангуут болохгүй болчихдог энэ муухай зарчимгүй байдлаа болимоор байна Их Хурлын гишүүд ээ. Ялангуяа энэ дарга сайд нар. Тэгээд л нэг жирийн гишүүн юм асуунгуут л болохгүй, та мэдэхгүй байна эд нар гээд л нэг хүн доош нь хийж байгаа юм шиг.

Д.Амарбаясгалан: Доржзодовын Энхтуяа гишүүн асуулт асууя.

Д.Энхтуяа: Өдрийн мэнд хүргэе. Зарим асуулт давхцаж байгаа учраас заримыг нь хасъя. Засгийн газар гадаад өр бол 37 тэрбум доллар болсон байна үгүй юу Монгол Улсын. Засгийн газар гадаад өр бол 8 тэрбум гээд энэ гадаад өрийн энэ мэдээллийг авлаа. Одоо ингээд энэ Засгийн газар бол 14 мега төслийг ер нь ихэнхийг нь гадаад өр зээл, тусламж, бонд, үнэт цаасаар санхүүжүүлнэ гэсэн ийм чигтэй байгаа. Засгийн газар 14 мега төслөөс гадна Улаанбаатар хот дээр 24 мега төсөл гээд л гадаад өр зээлээр хийгдэх ийм төслүүдийн асуудал яригдаж эхэлсэн байгаа.

Тэгэхээр 2026 оны энэ төсвийн хүрээний мэдээлэл төсөөлөлдөө энэ өрийг гадаад өрийг хэчнээнээр нэмэгдүүлэх юм. Яг одоо ямар төсөлд хэдэн долларын хэдэн үнэт цаасаар, ямар үнэт цаасаар, ямар өрийн бичиг, ямар бондоор энэ 14 тэгээд дээрээс нь Улаанбаатар хотын нэмэх 24 мега төслийг санхүүжүүлнэ гэсэн ийм төсөөлөл төлөвлөгөө байгаа вэ? Энэ дээр та хариулах боломж байна уу? 1 дүгээр асуулт.

Хоёрт нь яах вэ бид нар бол 2025 оны төсвөө бол алдагдалгүй баталсан гэж байгаа боловчиг ерөнхийдөө төсвийн төсөөллөө бол маш өөдрөгөөр төсөвлөдөг. Ингээд яг одоо төсөв бүрдүүлэх ингээд энэ агшинд ерөнхийдөө төсвийн бүрдүүлэлт маш хэцүү болдог. Харамсалтай нь өнгөрсөн жилүүдэд төсвийн тодотголыг хийхгүйгээр энэ төсөв бүрдүүлэлт асуудал үүсэнгүүт ард иргэдийн нуруун дээр янз бүрийн татвар юу байдаг юм хураамжаа нэмж энэ төсвийг ингэж бүрдүүлж ирсэн. Энэ ерөнхийдөө бол энэ сүүлийн үеийн Засгийн газар хамгийн сайн хийж сурсан зүйл гэж ингэж харагдаж байна аа.

Тэгэхээр 2026 оны энэ төсвийн төсөөлөлдөө энийг бол яаж тусгаж өгч байгаа юм бэ? Энэ Монголбанктай бодлого үйл ажиллагааны ямар нэгэн уялдаа холбоог бий болгосон зүйл одоо энэ 2026 оны төсөөлөлд орж ирсэн үү? 2 дугаар асуулт.

Гуравт нь инфляц өсөх сая бол ерөнхийдөө олон гишүүд бас хэллээ. Инфляц өсөх хандлагатай байна.

Хоёр оронтой тоонд ч орно гэсэн ийм судлаачдын дүгнэлтүүд гарсан байгаа. Тэгэхээр энэ Монголбанктайгаа энэ үйл ажиллагаагаа мэдээжийн хэрэг ярьж хөөрч бодлого үйл ажиллагаагаа төсөөлж орж ирсэн байх гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр та Сангийн сайд яг ямар чиглэлээр ямар хууль бүрдүүлэлтэд уялдаа холбоог нь зохицуулж энэ төсвийн төсөөлөлдөө оруулж ирж байгаа вэ гэсэн ийм 3 асуултад хариулт авъя аа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд.

Б.Жавхлан: Энэ чинь Э.Энхтуяа гишүүнээ Засгийн газраас оруулж ирж байгаа тоонууд л даа. Зүгээр яг Сангийн сайдын хувиар гэх юм бол бид саналаа өгөөд явдаг юм байгаа юм. Ялангуяа энэ яг төсвийн орлого зарлагаас бусад тоонууд дээр бол энэ Төв банктай бол нэлээн бодлогоо уялдуулж тооцооллууд дээрээ хамтарч сууж ингэж оруулж ирдэг ийм тоонууд байгаа. Бид нар өмнө нь ингэж л хийдэг байсан. Одоо Эдийн засгийн хөгжлийн яам хариуцдаг болсон учраас нэг их хол хазайгаагүй болов уу гэж ингэж бодож байна. Тийм тэгэхээр сая та нэлээн деталь асуулт асуулаа. Тийм учраас Эдийн засгийн хөгжлийн яамнаас хариулсан нь зөв байх аа. Батхүү дарга хариулчих уу?

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индэр.

И.Батхүү: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя аа.

Яг төсвийн хүрээний мэдэгдэл дээр ордог гадаад өртэй холбоотой тооцоо нь бол Засгийн газар өрийн хэмжээг ДНБ-д эзлэх хувь хэмжээгээр заадаг байгаа. Бид нарын оруулж ирсэн төсөл дээр бол 2026 онд 50 хувь, 2027, 2028 онд 45 хувь байхаар ер нь өрийн төсөвт үзүүлж байгаа Засгийн газрын өрийн хэмжээг бууруулах чиглэлээр оруулж ирсэн байгаа. Ер нь бол түрүүн дурдагдсан тэр татварын холбогдолтой асуудал дээр бид нар ДНБ-д эзлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын нийт хэмжээг нь хувь хэмжээг нь бууруулж тооцсон байгаа. Ирэх 3 жилд.

Тухайлбал 2026 онд 31.7 хувь, 2027 онд 30.4 хувь, 2028 онд 29.6 хувьд хүргэхээр. Энэ ДНБ-д эзэлж байгаа. Тэнцвэржүүлсэн орлогын хувь хэмжээг бууруулна гэдэг нь дунд хугацаандаа энэ татварын багц хуулиудыг өөрчлөх реформыг үе шаттайгаар хийх орон зайг нь бид нар ингэж гаргаж өгч байгаа. Энэ хүрээндээ холбогдох хууль тогтоомжид нь өөрчлөлт ороод явах байх аа. 14 мега төсөл болон нийслэлийн 24 мега төслийн хувьд бол төсөл болгоны хэрэгжүүлэх салбар онцлог онцлог байгаа.

Төслийн санхүүжилтийн модель загварууд нь өөр байгаа. Эх үүсвэрийн төрөл нь өөр байгаа. Энэ бүгдэд нь тохирсон нэг төслийн бэлтгэл ажлууд яваад үе шаттайгаар санхүүжилт нь шийдэгдээд явна аа. Үүнтэй холбоотой санхүүжилтийг босгохтой холбоотой хууль эрх зүйн орчин дээр бол Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлтийн төслийг Засгийн газар зүгээс

бэлдээд ажиллаж байгаа. Мөн гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчилсэн өөрчлөлт бусад энэ бизнесийн орчныг сайжруулах хууль тогтоомжуудыг өөрчлөх реформ хийх чиглэлээр ажиллаж байгаа. Энэ хүрээнд гаднын шууд хөрөнгө оруулалт бас төр хувийн хэвшлийн түншлэлээр энэ томоохон төслүүдийн санхүүжилтийг төсөвт аль болох дарамт учруулахгүйгээр шийдэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Инфляцтай холбоотой асуудлыг түрүүн тайлбарласан. Өмнөх асуулт дээр. Үндсэн олон хүчин зүйл дундаас төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ялгаатай нь бол төсвийн зарлагын хэмжээг манай яамны тооцоолол 2.3 их наядаар 2026 онд бага байгаа. Тэгэхээр энэ төсвийн бодлого талдаа бол энэ нөлөөллийн зөрүү нь гарч ирж байгаа. Монголбанктай мэдээж төсвийн бодлого мөнгөний бодлогыг уялдуулах хоорондоо санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээр бол тухайн үедээ бас энэ нөхцөл байдлаа ярилцаад явдаг. Тэгэхээр бодлогын хүүг өөрчлөх ч юм уу бусад асуудлууд нь тэрэн дээр уялдаад явна гэж хэлж болно.

Д.Амарбаясгалан: Энхтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Энхтуяа: Тэгвэл Эдийн засгийн яамнаас дахиад тодруулга авчихъя. Одоо гадаадын зээл тусламж, үнэт цаас, бонд гээд энэ дээр бол ерөнхийдөө ач холбогдол өгч байгаа. Энэ дээр найдлага байгаа гээд тэгж байна. Тэгэхээр гадаад энэ зах зээл энэ гадаад улс төрийн нөхцөл байдал геополитикийн нөхцөл байдал гээд маш өөрчлөгдсөн байгаа. Тэгэхээр энэ дээр та бүхэн судалгаа хийсэн үү? Ерөнхийдөө бас хэрэгжих бодит боломж нь ямар байгаа бол?

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс ТНБД Батхүү хариулт өгье.

И.Батхүү: Гадаад нөхцөл байдлыг манай яам байнга ажиглаж судалгаанууд хийж ажиллаж байгаа. Ялангуяа олон улсын худалдаан дээр үүсэж байгаа тарифын өөрчлөлтүүд, улс орнуудын харилцан авч байгаа арга хэмжээнд байнга ажиглаж байгаа. Хамгийн сүүлийн жишээ гэх юм бол Америк, БНХАУ хооронд харилцан тарифаа 115 хувиар 90 хоногийн хугацаатай бууруулах шийдвэр гаргасан. Тэгээд бусад улс орнууд ч гэсэн ер нь хэлцэл хийгээд явж байгаа. Мэдээж энэ гадаад нөхцөл байдлын нөлөөллийг манай хамгийн том худалдааны түнш гол экспортын орлогоос хамаардаг БНХАУ-ын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бид нар тусгайлан авч үзэж байгаа. Ойрын 2 жилийн хувьд энэ сөрөг нөлөөллүүд гарна гэсэн тооцооллууд олон улсын байгууллагууд болон манай яамны дотоод тооцоолол дээр гарч байгаа. Үүнтэй холбоотой эрсдэлийг тооцоод бид нар түрүүн дурдсан. Тодорхой хэмжээний өсөлтийн тоо хэмжээгээ өмнөх онд гаргаж байсан тэй харьцуулахад бууруулж тооцсон асуудлууд байгаа.

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Ингээд өнөөдөр бид 2026 оны төсвийн хүрээ хэлэлцэж байгаагаас гадна мөн Засгийн газар өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийг батлах тухай энэ чухал зүйлийг хэлэлцэж байна. Тэгээд бас энэ ташрамд энэ танилцуулгыг харж байхад нэг зүйлийг бид ярих ёстой. 2016 онд Монгол Улсын Засгийн газар өр бол ДНБ-ий 93 хувь орчим байсан бол одоо 2024 оны байдлаар 41 хувь болж огцом буурсан. Тэгэхээр энэ Засгийн газар бас сүүлийн жилүүдэд маш сахилга баттай энэ өрийн удирдлага дээр маш сайн ажиллаж байгаагийн нотолгоо. Энэ ч үүднээсээ бас олон улсын хэмжээнд бидний зээлжих

зэрэглэл маань өндөрсөж байна. Бид одоо гадаад зээл ярихдаа зүгээр урсгал зардлаа нөхөх ч юм уу бид нар эдийн засгийн үр өгөөжтэй томоохон төслүүдээ санхүүжүүлэх гэдэг ийм юм ярих хэмжээний болно оо гэдэг бол нэлээд эерэг зүйл ээ.

Тэгэхээр энийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Харин урагшаагаа хараад бид энэ 2026-2028 оны стратегийг харахад өнөөгийн нөхцөл байдлыг харахад ч гэсэн бид нар тайвширч болохгүй. Анхаарах ёстой хэд хэдэн зүйлсүүд байна. Зөвхөн өнөөдөр гэхэд манай энэ улс төрийн бужигнаанаас болж Засгийн газраас гадаадад гарсан бондуудын үнэ огцом унаж байна. Энэ манай төгрөг дээр ирэх дарамт үнийн өсөлт нэмэгдэх гэх мэтчилэн маш олон зүйлсүүд болно. Яах вэ нэг талдаа зарим хүмүүс огцрох амархан гэж хэлж байна. Гэхдээ эдийн засгийн өсөлтийг авчрах төрийг тогтвортой байлгах гэдэг бол маш хэцүү. Тэгэхээр энэ одоогийн эдийн засгийн хувьд би улс төрийн хувьд яриагүй. Эдийн засгийн хувьд байгаа энэ тогтворгүй байдал энэ 2025 оны хувьд эхний улиралд гэхэд эдийн засгийн өсөлт 2.4 хувь болж удааширсан байна. Биднээс хамаарсан биш гадаад нөхцөл байдалтай холбоотой ч зүйлсүүд байна. Инфляц 8.6 хувь буюу аль хэдийн төсвийн хүрээндээ оруулсан тооноосоо ингээд өндөр хэвээрээ байна аа.

Тэгэхээр энэ дээр цаашдаа та бүхэн энэ 2028 оны төсвийн хүрээг ярьж байгаа зөвхөн ирэх жилийг гэж хэлэлгүйгээр би Жавхлан сайдаас, Сангийн сайдаас асуумаар байна. Энэ жилийн 2025 оны менежментийг яаж хийх гэж байна вэ? 2025 оны менежмент бол өөрөө 2026-2028 оны суурь учир энэ шууд хамааралтай зүйл гэж бодож байна. Өнөөдөр болж байгаа энэ эдийн засгийн шоктой ямар хариу үзүүлэх гэж байна? Ямар бодолтой сууна вэ гэдгийг асууя.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Э.Болормаа: Болормаа гишүүний асуултад хариулъя аа.

Тийм ээ бид 2012 онд зээлжих зэрэглэлээ алдсан. Харамсалтай нь энэ маань 12 жилийн дараа 2024 онд бид тэр түвшиндээ арайхийж очсон, арайхийж очсон. Энэ хооронд бид нар маш их хүнд үеүдийг туулсан байдаг. Маш их өртөгтэйгөөр тэр зээлжих зэрэглэлийнхээ түвшнийг эргүүлж олж авч чадсан. Энийг ойрын жилүүдэд бид дор хаяж энэ түвшиндээ хадгалах улмаар сайжруулах ийм зорилт тавьж ажиллаж байгаа гэсэн үг.

Өмнөх жилүүдэд бид өрийн удирдлагаа амжилттай хийсэн. Дараагийн жилүүдэд ирж болох энэ дарамтуудыг нимгэлж чадсан, бууруулж чадсан, хойш нь төсөв дээр дарамтгүйгээр жигд хуваарилж чадсаны үр дүнд бид ноднин зээлжих зэрэглэлээ ингэж ахиулж чадсан байгаа юм.

Тэгэхээр 2025 онд бид нар төлбөл зохих ёстой байсан 650 сая долларын өрийг бид нар өмнөх жилүүдэд зохицуулалт хийхийг нь хийгээд төлөхийг нь төлчихсөн байгаа. Тийм учраас одоо 2025 онд бид дахиж тулсан бондын өр байхгүй. 2026 онд ч байхгүй, харин урт хугацаатай мөн олон талтын болон 2 талт хөгжлийн төслүүд дээр авсан урт хугацааны хөнгөлөлттэй зээлүүдийн төлбөрүүд байгаа. Энийгээ төсөв дээрээ багтаагаад явж байгаа. Томоохон төсөл хөтөлбөрүүдтэй холбож та асууж байх шиг байна. Тэгэхээр ер нь аль болох бид нар төсөв дээрээс дахиж баталгааг тэр томоохон төслүүд рүү чиглүүлэхгүйгээр дахиж төсөл хөтөлбөр

санхүүжүүлэх богино хугацаатай өндөр хүүтэй бонд авахгүй ийм стратегиа оруулж ирж байгаа гэсэн үг.

Дээрээс нь хэрвээ бид 2 талтын болон олон талтын төсөл хөтөлбөр авлаа гэхэд дандаа прожект файнансинг буюу төсөл нь өөрөө өөрийгөө санхүүжүүлээд явах ийм л төсөл хөтөлбөрүүд дээр зээл авна. Тухайлбал бид хэдхэн сарын өмнө Улсын Их Хурлаар оруулж батлуулсан нефть боловсруулах үйлдвэр байна. Энэ төсөл бол Монгол Улсын хамгийн том зээлийн санхүүжилтээр бий болж байгаа төсөл. Энэ төсөл маань хугацаандаа ашиглалтад оруулж яаралтай бид үр өгөөжийг нь бүртгэх хэрэгтэй байгаа. Тэгж чадваас бид жил бүр бензиндээ төлж байгаа 2 тэрбум долларын чинь талыг нь ядаж авч үлдэх юм байгаа юм. Ийм үр дүнтэй төслүүд дээр л сүүлийн жилүүдэд Засгийн газар зээл авч байгаа гэсэн үг. Тэрнээс биш сандал ширээ, байшин санхүүжүүлэх, яваандаа төсөв дээр ачаалал зардал нэмэх ийм нийгмийн шинжтэй төсөл хөтөлбөрүүдээс аль болох татгалзаж байгаа.

Ийм дараагийн 3 жилийн төлөвлөгөө орж ирж байгаа гэдгийг хэлье. Ингээд дахин хэлье. Энэ жил болон хойтон жилийн тулчихсан байсан бондын өрүүдийг бид аль хэдийн өмнөх жилүүдэд амжилттай зохицуулалт хийсэн байгаа. Тийм учраас.

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн тодруулж асууя.

Э.Болормаа: Жавхлан сайдаас Сангийн сайдаа би нөгөө асуугаад байгаа зүйл нь аль хэдийн энэ эхний улиралд удааширсан байгаа эдийн засгийн үзүүлэлтүүдээр ямар бодолтой байгаа, тасалдаж байгаа төсвийн орлого дээр ямар бодолтой байгаа вэ? Энэ бол 2026-2028 оны төсвийн хүрээний суурь юм гэж харж байгаа юм. Ер нь бол энэ төсвийн хүрээ, энэ өрийн стратегийн баримт бичиг бол зүгээр нэг баримт бичиг биш. Бид нар Монголын ирээдүйд итгэж байгаа улс төрийн шийдвэрийг илэрхийлж байгаа. Энд ярилцах ёстой нь зөв. Аль хэдийн энэ ордон доторх сандал суудлын хэрүүлээс болж эдийн засагт бодит сөрөг нөлөө гарч байна аа. Энэ дээр ямар бодолтой байна аа? Ямар хариу арга хэмжээ авах гэж байна? Энэ 2026 оны суурь юм шүү гэдгийг тодруулъя.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Болормаа гишүүний асуултад нэмж хариулъя. Төсвийн хувьд бид нэгэнт алдагдалгүй төсөв баталчихсан. Энэ жилийн төсвийн орлого талдаа бид бас нэлээн сорилттой байгаа. Гэсэн хэдий ч Засгийн газарт орж ирж байгаа орлогынхоо түвшинд төсвийн зардлаа зохицуулалт хийгээд явах бүрэн эрх үүрэг нь байдаг. Энэ хүрээнд эхний одоо хагас жилийн хувьд бид одоо Засгийн газар төлөвлөгдсөн бүхий л үйл ажиллагааг орлогодоо тааруулаад ямар ч тасалдалгүйгээр бүрэн санхүүжилт хийгээд явж байгаа гэсэн үг. Сүүлийн хагастаа ч тэгнэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл, орлого ямар хэмжээнд, яаж дутна тэр хэмжээнд энэ жил зарцуулалт гарна гэсэн үг юм байгаа юм.

Тэгэхээр энэ жилийн хувьд бол төсөв дахиад алдагдалгүй гарах гүйцэтгэл ингэж гарах бүрэн боломжтой. Гэхдээ энэ бол том сорилт. Ингээд нэг зүгээр төлөвлөгдчихсөн байсан төсвөө танаад яваад байх нь өөрөө энэ хөгжлийн төлөвлөлтөд алдагдалтай.

Тийм учраас бид дунд урт.

Д.Амарбаясгалан: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууя.

Г.Уянгахишиг: Ерөнхийдөө ихэнх асуултуудын маань хариултууд бас өмнөх гишүүдийн асуултуудаар давхцаад явчихлаа. Жишээлэх юм бол одоо яг энэ төлөвлөгдөж яригдаж байгаа Татварын багц хуулийн нөлөөллийг оруулсан байгаа болов уу? Мөн түүнчлэн яг энэ төсөвт нөлөөлөхгүйгээр санхүүжилт эх үүсвэрүүдийг ашиглах боломж гаргах энэ тал дээр нөлөөллүүд нь тусаад орсон юм болов уу гэсэн ямар ч байсан тусгаад явчихсан байгаа юм байна. Мөн түүнчлэн яг энэ төсөв батлах үед өнгөрсөн төсөв 2025 оны төсөв батлах үеэр бол төсвийн хүрээний мэдээллийг өөрчилж байсан. Тэгэхээр энэ жил ийм юм давтагдахгүй байх гэдэг хүлээлттэй байгаа. Тэгээд энэ утгаараа бас нэг асуудлыг тодруулаад асуучихмаар байна. Гадаад худалдааны урсгал тэнцэл дээр бид нар ерөнхийдөө алдагдалтай гараад байна. Тэрэн дээр ер нь бол нэлээн асуудал үүсээд байсныг бол ойлгож байгаа. Одоо энэ танилцуулга дээр бичсэнчлэн Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2026-2028 онд дунджаар 3.2 орчим тэрбум ам.долларын ашигтай байх төлөвтэй байна гэсэн байна.

Тэгэхээр энэ дээр нөлөөлж байгаа нөлөөллүүдээс нэг тодруулж асуух юм бол 1 дүгээрт ер нь бол алт олборлолтыг дэмжих арга хэмжээнүүд хэрэгжих учраас алтны тушаал алт тушаалт болон олборлолт нэмэгдэнэ гэсэн байна. Тэгэхээр энэ дээр ямар бодлого ямар хөтөлбөрүүд байгаа юм бол оо. Энэ талаар мэдээлэл өгөөч?

Мөн энд хөдөө аж ахуйн болон боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр ноолуур, арьс шир, мах, малын мах зэрэг уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт дунджаар 10 орчим хувиар өсөхөөр байна гэж байгаа. Тэгвэл энэ өсөлтийг хийх боломжтой тэр үйлдвэрүүд төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг яг энэ төлөвлөхдөө ямар санхүүжилтийн эх үүсвэрээр төлөвлөсөн байгаа вэ? Нөгөө гадаад зээллэг эсвэл төр хувийн хэвшлийн түншлэл гэдгээр төлөвлөчихсөн байдаг. Нөгөө яг энэ санхүүжилт маань шийдэгдэхгүй байх хууль эрх зүйн орчин бүрдэхгүй байх ийм нөхцөл байдлууд үүсэх юм биш биз гэдэг 2 дахь асуулт байна.

Гуравдугаарт болохоор мөн энэчээ 2026 оноос бүтээн байгуулалт шинээр эхлэх, зэс хайлуулах үйлдвэр, гангийн үйлдвэр, нүүрс химийн цогцолбор зэрэг том төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр импортын өсөлт дунджаар 8 орчим хувьд хадгалагдахаар байна гэж байгаа юм. Тэгэхээр яг энэ үйлдвэрүүдийг барих санхүүжилтийн эх үүсвэрийг бас яг яаж харж байгаа вэ? Нөгөө өмнө нь тохиолдож байсан асуудлууд буюу нөгөө төсөвтөө баригдаад бид нар энийгээ ашиглалтад оруулж чадахгүй юм уу, хэрэгжүүлж чадахгүй асуудал үүсэх юм биш биз дээ? Тэгвэл энэ нөгөө гадаад худалдааны урсгал тэнцэлд нөлөөлөх нөлөөлөл үүсэх үү гэдэг ийм асуултуудыг асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Эдийн засаг хөгжлийн яамны ТНБД Идэшийн Батхүү 4 дүгээр индэр.

И.Батхүү: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя.

Тэгээд алтны экспорттой холбоотой бид нар энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр тооцож байгаа энэ алтны экспортыг нэмэгдүүлэх гэдэг нь бол төсвийн орлого гэхээсээ илүү нөгөө гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх үр нөлөө их

өндөртэй. Тэгээд одоо яригдаж байгаа зарим алт 3 гээд хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх, тэгээд тодорхой орд газар гэвэл Баян хөндийн алтны орд дээр 2.4 тонны нэмэлт олборлолт 2026 онд хийгдэнэ гэсэн тооцоо байгаа юм байна. Тэгээд алт 3 хөтөлбөрийнхөө нөлөөллөөр ингээд 2027-2028 онд 24 тонн алтыг гаргая гэсэн тийм зорилт гэж хэлж болно. Түрүүн дурдсан томоохон төслүүдийг бол нөгөө төслийн санхүүжилтийн загвар нь өөр өөр байгаа. Жишээ нь таны дурдсан тэр нүүрс, химийн цогцолбор, кокс химийн цогцолбор, алт боловсруулах үйлдвэр, зэс боловсруулах үйлдвэр гэдэг төслүүд маань Эрдэнэс Монгол дээр нөгөө байгаа ордууд, байгаа үйлдвэрүүдийнхээ нөөц бололцоог түшиглээд үнэлгээ хийгээд ТЭЗҮ судалгааг нь хийгээд явж байгаа. Энэ ТЭЗҮ судалгаа дээр нөгөө эдийн засгийн хэрэгжүүлэх боломж гэдэг агуулгаараа санхүүжилтийн төрлүүд санхүүжилтийн өртөг, хугацаа, эргэж төлөх хугацаа гээд эдийн засгийн үр ашгийн тооцоонд давхар гарч ирнэ. Одоо байгаа мэдээллээр бол яг төсвөөс санхүүжүүлэх биш тухайн ТӨК-ийн өөрийнх нь бололцоо тодорхой тэдэн хувь, дээр нь нэмээд гадаадын шууд хөрөнгө оруулалт хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлнэ гэсэн төлөвлөгөөтэй явж байгаа юм байна лээ.

Эдгээр төслүүдийг идэвхжүүлэхийн тулд тодорхой ажлын хэсгүүдийг Засгийн газар түвшинд гаргаад сайд нар ахлаад тодорхой тэр ТӨК-удаас нь оролцоод бэлтгэл ажлыг хангаад явж байгаа.

Д.Амарбаясгалан: Уянгахишиг гишүүн тодруулж асууя.

Г.Уянгахишиг: Эдгээрийг яагаад тодруулж тухайлан асуугаад байгаа юм бэ гэхээр бид нар яг нөгөө гүйцэтгэлүүдээ хэлэлцсэн. Тэгэхээр яг энэ гүйцэтгэл дээр бол төлөвлөгөөний гүйцэтгэл, гүйцэтгэлийн тайлан дээр бол яг төсвийн бус эх үүсвэрээр санхүүжих төслүүд дээр санхүүжилтийнхээ эх үүсвэрийг ерөөсөө босгож чадахгүй байх. Тэрэн дээр төр хувийн хэвшлээр хийнэ гэсэн ажлууд хийгдэхгүй байх ийм нөхцөл байдлууд их өндөр үүссэн байсан учраас эд нарыгаа энэ төсөл хөтөлбөрүүд цаашдаа яг энэ санхүүжилтийн эх үүсвэрүүд нь шийдэгдээд явах юм гэдэг энэ баталгаа яг энийг хэрэгжих боломжийг сайн хангаж ажиллахгүй бол мэдээж энэ бол нарийн яг төсвөө ярьж байгаа биш нөгөө талаасаа яг төсөл хөтөлбөрүүдээ нарийвчилж ярьж байгаа биш тэрийг нь ойлгож байгаа. Гэхдээ яг энэ төсвийн хүрээний мэдэгдлээ тухайн төсөв батлагдах болгондоо өөрчилж явмааргүй байгаа юм. Тэгэхээр энийгээ илүү баталгаатай.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогоо байж болох хамгийн доод хэмжээгээр нь төлөвлөсөн гэж байгаа юм. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн зарлагыг болохоор байж болох хамгийн дээд хэмжээгээр нь 33 их наяд 479.5 тэрбум гэж ингэж тооцоолж оруулж байсан.

Ингээд энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл. Тэгээд ингэж явж тооцоолдог тооцооллын арга чинь хэр бодитой юм бэ? Орлогоо болохоор хамгийн доод хэмжээгээр тооцоолдог гол нь хамгийн гол нь зардлыг байж болох хамгийн дээд хэмжээгээр нь ингэж тооцоолж явдаг чинь ямар учиртай юм бэ? Харин эсрэгээрээ зардлаа байж болох хамгийн доод хэмжээгээр нь төлөвлөж оруулж ирэх ёстой юм биш үү? Зардлыг.

Тэгээд бид нар ингээд бүүр сурчихсан. Төсөв орлого ДНБ нэмэгдэхийн хэрээр тэгээд л зардал нь гарч л байдаг, гарах ёстой гээд ингээд тооцоолчихдог. Орлого олохын хэрээр төсөв нэмэгдэхийн хэрээр зардлаа жоохон танаж хасаж нөөц бүрдүүлж баймаар байгаа байхгүй юу. Ерөөсөө ийм юм байхгүй ингээд л орлогодоо тааруулаад л ингээд л тэр хэмжээгээр зардал гарна гээд тооцоолоод оруулаад ирэх юм. Тэгэхээр Сангийн сайд минь эсвэл Эдийн засаг хөгжлийн яам энэ зарлагыг байж болох доод хэмжээгээр нь төлөвлөж оруулж ирж болдоггүй юм уу гэсэн л ийм асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эдийн засаг, хөгжлийн яам 4 дүгээр индэр.

И.Батхүү: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр тавигдаж байгаа зарлагын дээд хэмжээг нь зааж өгч байгаа. Яг одоо бодит байдал дээр салбарын яамдууд төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал зардлын хэмжээг аль болох өндөр байлгах олон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хүсэлт байдаг. Хүслийн жагсаалт гэдэг шиг. Энийгээ бид нарын хувьд яг хүссэн хэмжээнд нь тавьж өгөөд доод хязгаарыг нь тавья гэвэл эх адаггүй тийм их зардал нэмэгдэх боломжтой болно.

Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг маань өөрөө дунд хугацааны 3 жил дамнасан төсвийн бодлогыг харуулж байгаа баримт бичиг. Энэ хугацаандаа бас төсвийн бодлогоо нөгөө тэлэхгүй. Үйлдвэрлэлийн потенциалаасаа давсан өсөлтийн тамгатай байгаа үед төсвөө алдагдалгүй батлах тэр бодлогын зорилт байгаа учраас зарлагын дээд хэмжээг нь тавьж өгч байгаа. Төсвийн орлогын хувьд бол бодит нөгөө экспортын ч юм уу үйлдвэрлэлийн бодит хэмжээнүүдийг бодит секторуудын тооцоолол гадаад секторын тооцоолол дээрээ бид нар бодитой өсөлтүүдээ тооцож харж байгаа. Экспорт дээр жишээ нь экспортын биет хэмжээг аль болох зорилт учраас шахаж зорилт тавьж ажиллаж байгаа. Гэхдээ үнийн хувьд бол гадаад орчны нөлөөллийг харгалзаад илүү болгоомжтой тавьж өгч байгаа. Орлогын хувьд бол мэдээж бодит гүйцэтгэл дээрээ өндөр гарвал сайн, өндөр орлоготой байвал сайн. Төсвийн гүйцэтгэл нь цааш цаашаа ашигтай гарна. Зарлагын хувьд бол хязгаарлаж өгөхгүй бол бас хэтэрхий их зардал цаашдаа гарах, эдийн засаг тэлэх, төсөв тэлэх тийм үр нөлөө гарах юм.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуултаа асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй 5 санал байна аа.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг намын бүлэгт харьяалагддаггүй гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж болно. Урьдчилаад 3 гишүүний нэр ирсэн байгаа. Санал тус бүр дээр үг хэлэх боломж нээгдэнэ ээ. Гишүүд суудлаа эзэлье. Эдийн засгийн байнгын хороо түр завсарлав уу? Гишүүдийг орж ирж санал хураалтад оролцохыг дуудъя, мэдээлэл өгье.

Гишүүд орж ирлээ. зарчмын зөрүүтэй саналын томъёолол танилцуулъя.

Засгийн газар өрийн удирдлагын 2026-аас 28 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсгийн “буюу АНУ-ын тарифын бодлогоос шалтгаалж санхүүгийн зах зээлд тогтворгүй нөхцөл байдал үүсэхээс өмнө” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн.

Санал хураалт.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

47 гишүүн буюу 49 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Тогтоолын төслийн хавсралтын 2.7 дахь хэсгийн “2021 онд” гэснийг “2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр” гэж, “2024 онд” гэснийг “2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр” гэж, 3.1 дэх хэсгийн “02 дугаар сард” гэснийг “02 дугаар сарын 18-ны өдөр” гэж, 3.3 дахь хэсгийн “06 дугаар сард” гэснийг “06 дугаар сарын 16-ны өдөр” гэж, 3.5 дахь хэсгийн “09 дүгээр сард” гэснийг “09 дүгээр сарын 02-ны өдөр” гэж, 3.6 дахь хэсгийн “2021 онд” гэснийг “2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр” гэж, 3.7 дахь хэсгийн “05 дугаар сард” гэснийг “05 дугаар сарын 15-ны өдөр” гэж, 3.9 дэх хэсгийн “10 дугаар сард” гэснийг “10 дугаар сарын 04-ний өдөр” гэж, 3.11 дэх хэсгийн “2031 онд” гэснийг “2031 оны 10 дугаар сарын 28-нд” гэж, 3.12 дахь хэсгийн “08 дугаар сард” гэснийг “08 дугаар сарын 29-ний өдөр” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн.

Даваасүрэн гишүүн саналаа тайлбарлаж үг хэлнэ ээ.

Ц.Даваасүрэн: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Энэ 5 санал байна шүү дээ найруулгын. Хэрвээ энийг ингээд найруулгыг нь хийхгүй гаргачихвал энэ стратегийн баримт бичиг чинь 2028 он хүртэл үйлчлэх юм байна лээ. Тэгээд 1 тийм агуулгын алдаатай стратегийн баримт бичиг бол гарчихна шүү. Тийм учраас та бүхэн энэ найруулгын юмыг нь жаахан анхаарах хэрэгтэй. Сая хоёрхон хүнээр яачихлаа шүү дээ. Эхнийх ч одоо дүүрч чиглэл аваад өөрчилж болох байх.

Дараагийн юмнуудыг та бүхэн яг ингээд хугацаа нь энэ нэг найруулгын юмнуудыг сайн анхаарахгүй бол нэг тийм баримт бичиг дутуу агуулгын хувьд алдаатай баримт бичиг гарчих гээд байгаа юм шүү.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүний хэлж байгаа нарийвчилсан найруулгын шинж чанартай санал байгаа учраас Байнгын хорооных нь саналыг дэмжээд явах нь зөв байх гэж бодож байна аа.

Санал хураалт.

57.3 хувиар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн хавсралтын 4.8 дахь хэсгийн “эхлүүлэх” гэснийг “тогтмол явуулах” гэж, “тогтмол арилжаалах төлөвлөгөөтэй байна.” гэснийг “Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг эхлүүлээд байна.” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн.

Санал хураалт.

60.4 хувиар санал дэмжигдлээ. Сангийн сайд Болдын Жавхланг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

4.Тогтоолын төслийн хавсралтын Стратеги 4-ийн “Улсын төсөв ДНБ-ний 2 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай үед” гэснийг “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй үед” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн.

Санал хураалт.

59.4 хувиар санал дэмжигдлээ.

Сэддорж гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе ээ.

Найруулгын санал

1.Тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсгийн “түүхэн” гэсний өмнө “Засгийн газраас өмнө гаргаж байсан бондуудаас” гэж, 3.3 дахь хэсгийн “гаргасан” гэсний өмнө “баталгаа” гэж, 6.1 дэх хэсгийн “харьцааны төсөөллийг” гэсний өмнө “ДНБ-нд харьцуулсан” гэж, 6.2 дахь хэсгийн “хэмжээг 2026 онд” гэсний өмнө “ДНБ-нд эзлэх” гэж, “Дүгнэлт” хэсгийн “60.5 хувьтай” гэсний өмнө “2022 онд” гэж, “41.8 хувь” гэсний өмнө “2024 онд” гэж, “буурсан,” гэсний дараа “эдгээр онуудад” гэж тус тус нэмэх;

2.Тогтоолын төслийн хавсралтын 1.1 дэх хэсгийн “оршино” гэснийг “чиглэнэ” гэж, “Сангийн яам нь стратегийн баримт бичгийг” гэснийг “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичиг /цаашид “Стратегийн баримт бичиг” гэх/-ийг” гэж, 2.1 дэх хэсгийн “Цар тахлын” гэснийг “Ковид-19 цар тахал /цаашид “цар тахал” гэх/-ын” гэж, “2021 оноос 2024 оны хооронд нийт” гэснийг “2024 оны жилийн эцсийн байдлаар 2021 оны түвшнээс” гэж, “эзлэх хэмжээгээрээ” гэснийг “харьцуулсан харьцаа” гэж, 2.2 дахь хэсгийн “нэгжүүд” гэснийг “нэгж, байгууллагууд” гэж, 3.2 дахь хэсгийн “бүрдүүлэх” гэснийг “нэмэгдүүлэх” гэж, 3.5 дахь хэсгийн “зээлийн эх үүсвэрийг” гэснийг “зээлийг” гэж, 3.9 дэх хэсгийн “буцаан төлж” гэснийг “бүрэн төлж” гэж, Хүснэгт 6-ын “өрийн зардал” гэснийг “өрийн багцын зардал” гэж, 5.4 дэх хэсгийн “буурах төсөөлөл” гэснийг “бууралт” гэж, Стратеги 4-ын “бүх хэсгийн хүрээнд” гэснийг “нийт хэмжээнд” гэж, 5.8 дахь хэсгийн “үнэт цаасны гаргалтыг” гэснийг “үнэт цаасны арилжааг” гэж, 6.1 дэх хэсгийн “Засгийн газрын өрийн харьцаа” гэснийг “уг харьцаа” гэж, “өрийн харьцааг” гэснийг “уг харьцааг” гэж, 6.2 дахь хэсгийн “хүрээний мэдэгдэлд” гэснийг “төсөөлөлд” гэж, “туссан дүнтэй” гэснийг “туссан хязгаарт” гэж тус тус өөрчлөх;

3.Тогтоолын төслийн 2.2 дахь хэсгийн “Голомт банкнаас” гэсний дараах “олон улсын зах зээлд” гэснийг, мөн хэсгийн “төрийн байгууллагуудын хувьд” гэснийг болон “гаргасан, мөн тус хугацаанд” гэснийг, 2.4 дэх хэсгийн “тогтмол” гэснийг, 3.1 дэх хэсгийн “хуульчлагдаж” гэснийг, 5.8 дахь хэсгийн “түлхүү” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

54.2 хувиар санал дэмжигдлээ.

Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Саяын энэ найруулгын 3 дахь хэсгийн тэр хуульчлагч гэснийг хасаад байна шүү дээ. Энэ хасахаар найруулгын жоохон алдаа гарч байгаа юм байна лээ. Тэгэхээр тэрийг найрууллаа гэсэн чиглэл авчихъя.

Д.Амарбаясгалан: Боломжгүй сая санал хураагаад шийдэгдчихлээ үгүй үгүй.

Ц.Даваасүрэн: Чиглэл авч болно.

Д.Амарбаясгалан: Болохгүй айн санал хураагаад шийдчихлээ. Санал хураалтаас өмнө чиглэл авах хүсэлт өгөх байсан. Санал хураагаад шийдчихсэн байна.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хурааж дууслаа.

Эдийн засгийн байнгын хороо үргэлжлүүлэн хуралдаж санал хураалтаа үргэлжлүүлж явуулах боломжтой. Бид дараачийн асуудлаа эхлүүлнэ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газар өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

15.31 цагт

Дараагийн асуудалд орно. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Цэндийн Сандаг-Очир гишүүн уншиж танилцуулна аа. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хууль тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хууль тогтоолын төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй тул Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасныг үндэслэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асуухаар байгаа.

Идэрбат гишүүн Байнгын хороон дээр асуултгүй болсон уу? Идэрбат гишүүн асуулт. Нанзадын Наранбаатар гишүүн асуух уу? Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Энэ хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль чинь батлагдаад нэг жилийн ойн дээрээ ирээд ингээд хойшлогдох болчихож байгаа юм. Тэгээд энэ хойшлогдох болсон яг шалтгааныг нь би сайн ойлгохгүй л байгаад байгаа юм. Тэгээд эхний ээлжид надад яг яагаад хойшлогдчихсон юм, ямар үндэслэл шалтгаанаар хойшлогдчихсон юм гэдгийг нэг сайн тайлбарлаад өгөөч.

Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа бол Үндсэн хуулийн тэр дүгнэлт нь хаана байна, цэцийнх нь. Тийм, тэгээд хойшлогдоод хэдий хугацаагаар хойшлогдож байгаа юм. Нэг жилийн хугацаагаар хойшлогдож байгаа бол энэ хугацаанд Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж чадах юм уу? Тэр болж байгаа орон нутаг тухайлбал орон нутгийн чанартай хот тийм холбогдох заалтууд нь хэрэгжээд цаашаа явж байж болохгүй байгаа юм уу. Хэрвээ Дархан, Эрдэнэт нь болохгүй байгаа бол. Тэгээд энэ чинь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилж хөгжүүлнэ гээд л зөндөө юм яриад байгаа мөртөө ингээд хуулиа хойшлуулаад энэ чинь амилахгүй шүү дээ. Цаашаа явахгүй шүү дээ. Маш олон орон нутагт аймаг сумдууд хот болох тосгон болох гээд хүлээгээд бэлтгэл ажлууд хийгдээд ингээд явж байдаг. Тэгээд одоо нэг жил ч болоогүй ингээд хойшлуулна гээд ингээд явж байх юм. Тэгээд учир шалтгаан нь юу байгаа юм. Аль эсвэл дотроос нь зарим нэг зүйлүүдийг нь хэрэгжүүлээд явах түдгэлзүүлээд зарим заалтуудыг нь заримыг нь хэрэгжүүлээд явах боломж байхгүй юу гэсэн ийм асуулт байна.

Тэгээд тодруулъя. Ямар ч байсан хариулт сонсъё.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултад хариулъя.

Ц.Сандаг-Очир: Энэ чинь яагаад би хариулах билээ? Зүгээр манай Байнгын хороогоор.

Д.Амарбаясгалан: ТББХ-н дээр чинь танд энэ Улсын Их Хуралд энэ асуудлыг орж танилцуулахыг үүрэг болгосон байна шүү дээ. Тэгэхээр та гишүүдийн асуултад хариулна гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: Манай Байнгын хороон дээр яригдсан асуудал бол ажлын хэсгээс оруулж ирэхдээ яагаад хуулийг хойшлуулж байгаа юм бэ гэхээр нэг жилээр хойшлуулж байгаа юм. Бэлтгэл ажил шаардлагатай байна. Яг үндсэндээ бол үнэнээ хэлэхэд өнгөрсөн нэг жилийн хугацаанд хууль батлагдсанаас хойш хугацаанд бол хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр зарим нэг уулзалтуудыг хийсэн юм байна лээ. Эхний ээлжид Булган, Эрдэнэт, Сэлэнгэ, Дархан гэсэн аймгууд дээр энэ газар нутгийн хилийн цэгүүдийг тогтоох ажил хийгдээгүй байна. Хилийн цэсийн маргаантай байна гэдэг үндэслэлээр энэ хуулийн бэлтгэл ажил хангагдаагүй байна. Бэлтгэл ажлыг хангуулах шаардлагатай байгаа учраас хуулийг нэг жилээр хойшлуулахаар оруулж ирсэн. Тэрнээс Үндсэн хуулийн зөрчил маргаан ерөнхийдөө байхгүй гэж үзэж байгаа. 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр бас засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгж дэх хот байгуулж болно гэдэг ийм хуулийн заалт орсон шүү дээ. Тэгээд энэ заалтын хүрээнд хэрэгжүүлээд явахад бүрэн бололцоотой гэж ингэж үзэж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Наранбаатар гишүүн тодруулж асууя.

Н.Наранбаатар: Үгүй тэгээд энэ чинь нэгэнт батлагдсан хуулиа бэлтгэл ажил хангагдаагүй байна бид нар амжаагүй байна хойшлуулаадхаач гэж болдог юм уу энэ чинь. Их Хурал чинь хуулийг батална. ЗГХЭГ нь хэрэгжүүлэх ёстой юм байгаа биз дээ? Тийм тэгэхээр чинь яах ёстой юм? Нэг бол энэ хуулийг хэрэгжүүлж чадаагүй байгаа бэлтгэл ажлыг нь хангаж чадаагүй байгаа хүмүүст хариуцлага тооцох юм уу яах юм? Тэгээд хуулийг бид нар хэрэгжүүлэхгүй амжихгүй байна хойшлуулаад бай гээд яваад байх юм уу ямар учиртай юм? Энэ дээр Сандаг-Очир гишүүн тодорхой хариулт өгөөч.

Ц.Сандаг-Очир: Би бас яг тантай санал нэг байгаа. Өнгөрсөн хугацаанд энэ хуулийг яагаад хэрэгжүүлээгүй юм бэ? Засгийн газар гэдэг байр сууриа ч бас Байнгын хорооны хуралдаанд илэрхийлж байсан. Тэгээд бас Шижир гишүүн гээд хэд хэдэн гишүүд ч хүртэл яг тантай адилхан санал энийг хэрэгжүүлээгүйн төлөө хуулийг хэрэгжүүлэхгүйн төлөө хариуцлагын асуудлыг хөндөж байсан асуудлууд бий. Би бас яг тантай адилхан энэ хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа нэг жил юу ч хийгээгүй байсан учраас Засгийн газар хариуцлагагүй ажилласан байна аа. Энэ хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр. Ер нь сүүлийн үед Улсын Их Хурал дээр энэ 2 дахь удаагаа болж байна.

Улс төрийн намуудын тухай хуулийг батлаад мөн адилхан хэрэгжүүлэх хугацаа болсон боловч хуулийн бэлтгэл ажил хангагдаагүй гэдгээр бид нар өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлэх хугацааг нэг жилээр хойшлуулж байсан. Тэгээд цаашдаа ер нь Улсын Их Хурал дээр ийм буруу жишиг тогтчих вий дээ. Хэдийгээр Улсын Их Хурал батлаад байхад Засгийн газар бэлтгэл ажил хангагдаагүй гэдэг үүднээс 2 ч удаа энэ хууль.

Д.Амарбаясгалан: Наранбаатар гишүүн дахин тодруулж асууя.

Н.Наранбаатар: Одоо энэ орон нутагт үнэхээр тулгамдчихаад байгаа юм аа. Энэ хуулийн хэрэгжилтийг чинь нэлээд хүлээж байна. Тухайлах юм бро өнөөдөр

боомт дагасан хилийн боомт дагасан сууринууд бий болчихсон. Тухайлбал Гашуун сухайтын боомт дээр томоохон бүтээн байгуулалтын ажлууд хийгдээд ингээд Цагаан хад гээд энэ чинь 30 гаруй жил ингээд үүсчихсэн томоохон суурин байгаа юм.

Тэгээд өнөөдөр энэ Цагаан хаданд нэг 5-аас 15 мянган хүн ингээд зарим нь тогтмол зарим нь ирж очоод ажиллаж амьдарч байдаг. Эмнэлэг байхгүй, сургууль байхгүй, тоос шороотой, удирдлага байхгүй, засаг захиргаа байхгүй маш хүнд байдалтай л байгаа шүү дээ. Та бүхэн бараг бүгдээрээ очиж үзсэн л байгаа байх.

Тэгээд энэ мэтээс өгсүүлээд ингээд энэ хуулийг чинь хүлээсэн нэг эзэнтэй, засаг захиргаатай болчих гэсэн газрууд зөндөө байгаа шүү дээ. Тэгээд эд нарыгаа яаралтай эмх цэгцэд оруулах зайлшгүй шаардлагатай байгаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Сандаг-Очир гишүүн хариулт өгье.

Ц.Сандаг-Очир: Хуулийн ажлын хэсгийн ахлагчаар л Батлут гишүүн ажиллаж байгаа. Батлут гишүүн бас Наранбаатар гишүүний хариултад дэлгэрэнгүй бас яагаад хойшлуулах болсон үндэслэл шаардлагыг дэлгэрэнгүй танилцуулж өгнө өө.

Д.Амарбаясгалан: Батлут гишүүн хариулт өгье. Нэмж хариулъя.

Д.Батлут: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг гараад ажилласан. Монгол Улсын Засгийн газар хийж энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлыг тайлан мэдээллүүдийг авч сонссон байгаа.

Ингээд ер нь бол Засгийн газарт нэг ижил байр суурьтай ажлын хэсэг ч гэсэн нэг ижил байр суурьтайгаа нэг жилээр хойшлуулах саналыг оруулсан. Яагаад гэхээр бид бүхэн энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой зарим нэг асуудлууд дээр анхаарах шаардлага байна.

Нэгдүгээрт нь бол түрүүний Сандаг-Очир гишүүний хэлдэг зарим нэг орон нутгуудын хилийн эргэлтийн цэгүүдийг тодорхой болгох хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг батлах зэрэг асуудлууд байгаагаас гадна зарим нэг хуулийн зөрчилтэй холбоотой асуудлууд үүсэх магадлалууд бий болж байна гэж харж байгаа юм. Тухайлах юм бол Дархан-Уул, Орхон аймаг зэрэг газрууд дээр энэ аймгуудын нутаг дэвсгэрийг дагнасан хот бий болгоно гэхээр сум болоод багийн иргэдийн.

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье.

Д.Батлут: Сум багийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай холбоотой асуудлыг хэрхэх вэ гэдэг зохицуулалтууд байхгүй. Нэг ёсондоо төлөөллийн зарчим алдагдаад цаашлаад Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн зөрчил рүү явчих нөхцөл байдлууд үүснэ гэж харж байгаа.

Тийм учраас энэ хууль хоорондын зөрчилтэй холбоотой тухайн газар нутагтай холбоотой асуудлыг хэрхэн хууль эрх зүйн хүрээнд нь зохицуулж болох вэ гэдэг асуудлуудыг шийдвэрлэсний дараа энэ хуулиар хуулийн хэрэгжилтийг хангах тал дээр ажиллахгүй бол болохгүй байна. Тийм учраас бэлтгэл ажил зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: Амгаланбаатарын Ганбаатар гишүүн алга байна. Гомбын Ганбаатар гишүүн алга байна. Пунсалмаа гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 6 сарын 1-ний хуулиар бол Энэ Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан байгаа. Энэ Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль нь 2025 оны 6 сарын 1-ээс хэрэгжиж эхлэх ёстой байгаа.

Тэгэхээр энэ бэлтгэл хангагдаагүй байна гэдэг шалтгаанаар нэг жил хойшлох гэж байна аа. Тэгэхээр энэ бэлтгэл хангах ажлын хүрээнд төсөв эд хөрөнгө, эдэлбэр газар, засаг захиргааны зарим ажлуудыг шилжүүлэх энэ ажлууд нь хэдэн хувьтай явж байна аа? Энэ ажлуудыг ер нь хойшлуулсан. Нэг жил энэ хууль хойшлогдоход нөлөөлсөн Засгийн газар, яам тамга, энэ холбогдох албан тушаалтанд ямар хариуцлага хүлээлгэж байгаа юм. Ер нь бол бид нар хуулийн өмнө бол тэгш эрхтэй байх ёстой юм. Өнөөдөр ААН-үүд хувь компаниуд бол татвараа төлөөгүй бол данс фактураа хаалгаад ингээд бүх үйл ажиллагаа нь саардаг.

Гэтэл энэ төрийн байгууллага энэ яам, тамгын газрууд нь аливаа нэгэн хуулийг бол бүтэн жил гацаачихлаа. Энд бол Монгол Улсын төсвөөс хэдий их хэмжээний дахиад нэмэлт зардал гаргах юм? Энэ бол тодорхой хэмжээний эдийн засаг нийгэмд бол хохирол үзүүлж байгаа. Тэгэхээр энийг бол бид нар яаж хариуцуулах юм бэ? Ер нь бол стандартын хувьд бол энэ бид нар ижилхэн стандарттай байх ёстой байхгүй юу? Хувийн ААН-үүд ч ижилхэн, төр нийгэм ч гэсэн ижилхэн.

Хувь компаниудад болохлоор дабль стандарт тогтоож байгаа юм шиг. Тэгээд засаг нь болохоор энэ хуулиа ингээд нэг жил хойшлуулчихсан ингээд байгаад байна. Цаашлаад бол энийг бид нар энэ хуулийг нэг жил хойшлуулах гэж байна. Тэгэхээр энэ дахиад ийм асуудал үүсгэхгүй байхын тулд энэ ажлыг хэн хариуцуулж ямар агентлагуудад энэ ажлыг эзэнжүүлж өгч байгаа вэ гэдгийг асууя.

Д.Амарбаясгалан: Эрдэнэбүрэн сайд Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хойшлуулах асуудал.

Энэ бол энэ ТББХ-ны энэ дүгнэлтээс асууж байгаа шүү дээ. Ажлын хэсгээс. Пунсалмаа гишүүний асуултад хэн хариулж өгөх вэ? Үнэнбат хариулт өгөх үү? 4 дүгээр индэр.

М.Үнэнбат: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг өнгөрсөн оны 6 сарын 5-нд баталсан. Тэгээд дагуулаад хот байгуулах тухай 72 дугаар тогтоол гэж гараад 53 хотын асуудлыг баталсан байгаа. Тэгээд энэ тогтоолтой холбогдуулаад Ерөнхий сайд буюу Засгийн газарт бол хотуудын эдэлбэр газрын хэмжээ заагийг оруулж ир гэдэг ийм шийдвэрийн төсөл оруулж ирж Их Хурлаар батлуулах үүрэг чиглэлийг өгсөн байгаа. Тэгээд энэ хүрээндээ Засгийн газар аймгууд руу болон бусад энэ орон нутгийн зэрэглэлтэй хотуудтай холбоотойгоор эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох асуудлаар холбогдох ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Тэгээд энэ шийдвэрийн төсөл

маань орж ирж амжаагүй байгаа учраас 1 дүгээрт энийг хойшлуулах нэг үндэслэл байгаа.

Яагаад гэхээр тухайн орон нутгийн зэрэглэлтэй болон улсын зэрэглэлтэй хотын эдэлбэр газрын хэмжээ заагийг ингэж гаргасны дараагаар тухайн тэр хот дээр байх зөвлөлийн асуудал яригдаж эхэлнэ. Мөн тэр хотын захирагчийн асуудал яригдаж, хамгийн гол үндсэн суурь нь бол энэ хотын эдэлбэр газрын асуудал байгаа. Тэгэхээр энийгээ дагасан суурь, суурь асуудлууд явагдах учраас одоо ингээд 6 сарын 1-ээс ингээд хэрэгжээд эхэлчих юм бол аль аль талдаа хэрэгжилтийн шаардлага хангагдахад бол хүндрэл учирна гэж үзсэн учраас энэ хуулийн хэрэгжилтийг нэг жилээр хангуулах нь зүйтэй юм гэсэн ийм Засгийн газар хуулийн төслийг өргөн бариад орж ирж байгаа.

Ерөөсөө гол суурь үндэс суурь бол эхлээд эдэлбэр газрын хэмжээ зааг энэндээ суурилад зөвлөлүүдийн асуудал яригдана. Зөвлөл тэгээд нөгөө Хот тосгоны эрх зүйн байдлын хууль мөн дагуулсан хот Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолд заасны дагуу тодорхой чиг үүргүүдийг нь шилжүүлж ирж байгаа. Тэгээд тэр чиг үүрэгт шилжүүлэхийн тулд хотын зөвлөл ажиллах ёстой болж байгаа. Хотын зөвлөл бол дараагийн яг энэ хотын зөвлөлийн хууль батлагдаад энийг албан ёсоор энэ дараагийн зөвлөл байгуулагдах хүртэл бол тухайн ИТХ-ын төлөөлөгч нар үүргийг нь гүйцэтгэх ийм эрх хэмжээтэй байгаа. Тэгэхдээ энийг хийхийн тулд нөгөө тэр рүү очихын тулд Зөвлөлийн хууль гэж хууль бичих ёстой. Тэр зөвлөлийг яаж байгуулах юм, яаж сонгох юм? Хотын захирагчийг бол хотын нийт оршин суугчдын дундаас нь сонгох ёстой байгаа. Зөвлөлийг мөн хотын оршин суугчдын дундаас сонгох гээд ингээд энэ асуудлуудтай уялдаа холбогдолтой зөндөө зүйлүүд байгаа учраас энэ уялдаа хангахын тулд бол энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа.

Түрүүн Сандаг-Очир гишүүний асуусан асуултад хариулахад Үндсэн хуулийн зөрчилтэй холбоотой гэж орж ирж байгаа зүйл байхгүй. Үндсэн хуулийн зөрчилтэй байна гэж үзэх юм бол хэн нэгэн хүний мэдээллээр энэ цэц шийдсэний дараа энэ асуудал яригддаг учраас өнөөдрийн байдлаар бол Үндсэн хуулийн зөрчил гэсэн ойлголт байхгүй байгаа. Зүгээр энэ яг зохион байгуулалттай холбоотой энэ хуулийг хэрэгжүүлэх хүндрэл үүсэж болзошгүй юм гэдэг ийм хуулийг нэг мөр хэрэгжүүлэх шаардлага байгаа учраас нэг жилээр хойшлуулах нь зүйтэй юм гэж үзэж хуулийн төслийг оруулж ирж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос горимын саналтайгаар шууд эцэслэн баталъя гэсэн саналтайгаар орж ирсэн байгаа. Эдийн засгийн байнгын хороон дээр хөгжлийн төлөвлөгөө дээр гишүүд санал хэлж санал хураалт явагдаад байгаа учраас чуулганы танхим дахь санал хураалтыг хойшлуулъя. Дараагийн асуудалд оръё үг санал хураалт дээрээ үг хэлнэ.

15.49 цагт

Дараагийн асуудлыг хэлэлцье СЕХ-ны гишүүнийг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцүүлнэ.

ТББХ-ны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу СЕХ-ны гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр тогтоолоор СЕХ-ны гишүүнээр томилогдсон Д.Дэлгэрсайханы СЕХ-ны гишүүнээс чөлөөлөгдөх тухай өөрийн хүсэлтийг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлын даргад ирүүлсэн. Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг асуулт асууж, хариулт авсан болно.

СЕХ-ны гишүүн Д.Дэлгэрсайханыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн СЕХ-ны гишүүнээс чөлөөлөхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

СЕХ-ны гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх тэр ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Алга байна.

Санал хураалт. Нууц санал хураалттай. Гэхдээ гишүүд Эдийн засгийн байнгын хороон дээр санал хураалтад оролцож байгаа. Хөгжлийн төлөвлөгөө давхар хэлэлцэж явж байгаа учраас санал хураалтыг хойшлуулъя.

Дараагийн асуудал хэлэлцэж дуусаагүй байна тийм ээ. Хөгжлийн төлөвлөгөө. Байнгын хороон дээр энэ Эдийн засгийн байнгын хороон дээр өнөөдөр бараг 150, 160 гаруй санал хураалт явагдаж байна.

Тэгээд санал хураалт болгон дээр гишүүд асуулт асууж, үг хэлж байгаа учраас энэ хурал бол бараг 2 өдөр хуралдаад дуусахгүй байна шүү дээ. Тэгэхээр бид нэг дэх өдөр, 2 дахь өдөр чуулганы нэгдсэн хуралдааныг өглөө 11 цагаас нэг дэх өдөр, 10 цагаас намын бүлгүүд хуралдаад 11 цагаас чуулганы хуралдаантай.

Хоёр дахь өдөр өглөө 10 цагаас энэ чуулган үргэлжилж байж энэ хөгжлийн төлөвлөгөө төсвийн хүрээ 2-ыг Улсын Их Хуралд эцэслэж батлах боломжтой болж байна гэсэн үг.

Тэгэхээр ер нь 2-оос 3 өдөр тасралтгүй бид хэлэлцэж санал хураалт явагдаж байж энэ асуудал шийдэгдэхээр байгаа гэдгийг гишүүдэд мэдээлэл өгье.

Ингээд 7 дугаар асуудал байнгын хороонд хэлэлцэж дуусаагүй байгаа учраас дараачийн 8 дугаар асуудлыг оруулъя.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг уншиж танилцуулна.

Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо, Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан бөгөөд Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг 5 хоногийн завсарлага авсан болно. Завсарлагын хугацаа дууссан тул 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлэн явуулсан болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу Байнгын хороод 2025 оны 4 дүгээр сарын 9, 30-ны өдрүүдийн хуралдаанаараа хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулж дараах санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд ирүүлснийг танилцуулж байна аа.

Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийн хувьд тус байнгын хороо нь 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаараа Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг явуулсан байна аа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн.

Хууль зүйн байнгын хороо нь 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь уг асуудлаар Ажлын хэсэг байгуулах нь зүйтэй гэж үзээд ХЗБХ-ны 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолоор хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Уянгахишигээр ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, П.Сайнзориг нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан байна аа. Ажлын хэсэг 2025 оны 4 дүгээр сарын 11, 14-ний өдрүүдэд тус тус хуралдаж Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг бэлтгэхтэй холбоотой тусгайлсан танилцуулгыг ХЗБХ-ны 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанд танилцуулсны дагуу Байнгын хороо хуулийн төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын Тамгын газраар, хууль зүйн дүгнэлт гаргуулах түүнчлэн Монгол Улсын ХЭҮК, Улсын дээд шүүх болон УЕП-оос хуулийн төслүүдтэй холбогдуулан санал авахаар шийдвэрлэж хол холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Хууль зүйн байнгын хороо 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулж ажлын хэсгээс 12 зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан бөгөөд олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн. Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлэх үед Хууль зүйн байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй 12 саналыг татан авсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Ч.Анар нарын гаргасан 5 зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулсан.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйг бэлтгэсэн зарчмын зөрүүтэй Саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зөвшөөрлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ням-Осорын Учрал ЗГХЭГ-ын дарга, Монгол Улсын сайд, Г.Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч, Б.Батцэцэг ЗГХЭГ-ын дэд дарга, Н.Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Сүрэнхорол ЗГХЭГ-ын Засгийн газар ахлах референт, Золбоо ЗГХЭГ-ын салбарын бодлого зохицуулалтын газрын референт, Батболд ХХЗХ-ны зохицуулалтын газрын дарга, Лувсан-Очир Харилцаа холбооны зохицуул зохицуулах хорооны ажлын албаны дарга, Тайван ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга, Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Гантулга Дотоод

хэргийн их сургуулийн эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, Бат-Очир Дотоод хэргийн их сургуулийн цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй криминологийн тэнхимийн профессор.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүдээс урьдчилж нэр ирсэн байгаа. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн алга байна. Энхбатын Болормаа асуулт асууя.

Э.Болормаа: Миний асуулт энийг өргөн барьж байгаа Засгийн газар ажлын хэсэг болон Улсын Их Хурлын Тамгын газраас асуух гэсэн юм. Энэ Зөвшөөрлийн хууль бол цахим бооцоо түүний төлбөртэй холбоотой асуудал байгаа. Яг энэ асуудал дээр санал хураах Улсын Их Хурлын гишүүд дундаас үүнтэй хамаарал бүхий этгээдүүд байгаа юу? Бид хуулиараа тийм санал хураах энд оролцох ёсгүй түүнийгээ мэдүүлэх ёстой гэж би ойлгож байна. Тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газраас мөн Учрал сайдаас Учрал сайдаа танаас энэ асуултыг тодруулан асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Энэ Зөвшөөрлийн тухай хууль дээр Сайнзориг гишүүний ажлын хэсэг өнгөрсөн хугацаанд сайн ажилласан. Тэгээд үүний үр дүнд хууль батлагдах процесс явагдаад ингээд анхны хэлэлцүүлэг явж байгаад баяртай байна. Энэ хуулиараа бол ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй байдал тогтоогдох юм Их Хурлын гишүүн өөрөө санаачилгаараа энэ санал хураалтад оролцохоос татгалзах ийм хуультай.

Тийм учраас хэн нэгнийг нөгөө ашиг сонирхолтой юу эсэх үү гэдгийг тогтоох нь бол мэдээж хууль санаачлагчид байхгүй. Тийм учраас хэрвээ ашиг сонирхлын ямар нэгэн зөрчилтэй Их Хурлын гишүүн байвал өөрийнхөө саналаар энэ санал хураалтад оролцохгүй байж болно л гэдгийг хэлье дээ.

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн тодруулж асууя.

Э.Болормаа: Хэрвээ үүнтэй ашиг сонирхол зөрчилдөж байвал санал хураалтад оролцохгүй байж болно оо биш, оролцохгүй байх ёстой үүнийгээ мэдүүлэх ёстой ийм үүрэгтэй гэж би үзэж байна. Тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газар энэ асуудал дээр хариуцлагатай хандаад яагаад гэвэл олон нийт энэ асуудал дээр янз бүрээр л надаас бусад бүх гишүүд рүү ч гэсэн адилхан мессеж бичиж байгаа байх. Энэ их ашиг сонирхолд автсан асуудал юм биш үү? Энэ ONEXR дээр төдий чинээ айл амьдралууд мөнгө алдаж байгаа хэрээр зарим хүмүүс мөнгө олоод байна шүү дээ. Тэр ашиг сонирхол чинь энэ Улсын Их Хуралд нэвт орчихсон юм биш үү гэдэг ийм бодит зүйлийг асууж байна аа.

Тэгэхээр энэ дээр хариуцлагатайгаар Улсын Их Хурлын Тамгын газар энэ Улсын Их Хурлын гишүүдэд ийм зүйл байвал энийг хуулийн дагуу авч хэлэлцээсэй гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Ариунхур дарга хариулт өгье. 1 дүгээр микрофон.

Ч.Ариунхур: Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг зохицуулсан байгаа.

8.1.Улсын Их Хурлын гишүүн дараах бүрэн эрхтэй гээд 8.1.23 гишүүн хэлэлцэх гэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол тухайн асуудлаар хэлэлцүүлэг санал хураалтад оролцохоос татгалзах гэдэг бүрэн эрх байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ гишүүд санал хураалтад оролцохоос өөрсдөө татгалзах эрхтэй.

Д.Амарбаясгалан: Санал хураалтад оролцохоос татгалзах эрхтэй л гэж заасан байна шүү дээ. Тэгэхээр Тамгын газраас энийг зохион байгуулаад оролцох ёсгүй гэж гишүүдэд хандах боломжтой юм уу? Ариунхур дарга 1 дүгээр микрофон.

Ч.Ариунхур: Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм дээр Улсын Их Хурлын тогтоолоор баталсан ёс зүйн дүрэм дээр 4.12 хэлэлцэж байгаа асуудал нь ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол гишүүн энэ тухайгаа хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохоос сайн дураараа татгалзана гэсэн заалттай. Тэгэхээр одоогоор урьдчилсан мэдүүлсэн гишүүн байхгүй байгаа.

Д.Амарбаясгалан: Ийм байна шүү. Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууна. Алга байна. Энхтайваны Бат-Амгалан гишүүн асуулт асууя.

Э.Бат-Амгалан: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Зөвшөөрлийн тухай хуулийг ер нь агуулгынх нь хувьд бүрэн дэмжиж байгаа юм аа. Энэ цахим мөрийтэй тоглоом, энэ онлайн тоглоомыг бол хорихыг бүрэн дэмжиж байгаа. Гэхдээ энэ технологийн хувьд яг энэ хуулиараа бүрэн хорьчиход технологийн хувьд бид нар энэ хуулийнхаа дагуу хяналтаа тавиад байх ийм боломж бололцоо ер нь хэр байгаа юм бэ? Учрал сайдаас энийг асуух гэсэн юм. Жишээ нь БНСУ хуулиараа бүрэн хорьчихсон юм байна лээ. Гэхдээ 2024 оны судалгаагаар харахад БНСУ-д хэдий хуулиараа 100 хувь хорьсон боловчиг эргээд маш их олон хандалт авсан буюу энэ зүүн өмнөд Азидаа Солонгос бол энэ мөрийтэй тоглоомын өөрөөр хэлбэл нууц далд хэлбэр рүүгээ маш их орчихсон байна гэж ингэж харагдаж байгаа. Тэгээд 1 дүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал нь мэдээж энэ цахим мөрийтэй тоглоомоо хуулиараа хорино, нөгөө талд нь тэр бооцоот тоглоомуудыг хөл бөмбөг, сагсан бөмбөг гэдэг юм уу эд нарыгаа зөвшөөрлийг нь гаргаад ингээд энэ 2-ын хооронд уялдаа холбоог нь нэг талдаа хуулиараа хорьсон мөртөө нөгөө талдаа энэ бооцоот бусад спортын хэлбэрийг нь дэмжээд явахад яг саяын л дахиад асуулт, дахиад технологийн хувьд манайх хэр хяналт тавьж хэр ойлгомжтой байж ажиллаж чадах юм бэ гэж. Бүүр ингээд хорьсноороо улам нууц далд хэлбэрт орж далд хэлбэрт энэ залуучууд хүүхдүүд орох ийм боломж бололцоог нь бид нар хэр хориглож хэр тавьж явж чадах юм бэ гэж.

Энэ onexpert дэр нэг судалгаа гарсан байна лээ. Дэлхий дээр энэ платформуудыг эрэмбэлээд үзэхлээр onexpert ер нь 3 сая 500-аас 3 сая 600-д орж байгаа юм байна лээ. Нөгөө хандалт авдгаараа нөгөө тоглогчид хэрэглэгчид ордгоороо.

Тэгэхээр энэний чинь өмнө маш олон тийм яг ижил төстэй платформууд байна. 3 сая 500-д орж байна шүү дээ эрэмбээрээ. Тэгэхээр энэний урд байгаа тэр эрэмбэлэгдэж байгаа олон сайт энэ платформуудыг бас хэр хянаж чадах юм бол

доо. Үндсэндээ технологийн хувьд Монгол Улс хууль гаргаж болно бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Энэ хуулийг гаргахгүйгээр энэ бараг айл болгонд энэ асуудал хаалгыг нь тогшоод орчихсон байгаа шүү дээ. Хүүхэд нь, дүү нь, эр нөхөр нь тоглоом тоглодог энийг дэмжиж байгаа. Гэхдээ технологийн хувьд ер нь яг яаж хориглож хяналт тавьж явж чадах вэ гэдэг асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ цахим мөрийтэй тоглоомыг хориглох энэ хуулийг санаачилснаас хойш нэлээдгүй л хэлэлцүүлэг өрнөлөө л дөө.

Тийм учраас бол мэдээж энэ хуулийн цаана эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлгүүд байдаг. Тийм ч учраас энэ хуулийг батлахад бол нэлээдгүй цаг хугацаа шаардах шиг боллоо. Энэ зөвшөөрлийн хууль дээр бид яг энэ цахим мөрийтэй тоглоомыг тоглох, зуучлах, сурталчлах гээд бүх үйлдлүүдийг хориглож байгаа юм. Ингэснээрээ бид нар бол нэг 60 хувь бүрэн хязгаарлана гэдэг ийм эхний судалгааг хийсэн. Ингээд технологийн хувьд бол янз бүрийн тэр ви пи эн шиг төрлийн технологи ашиглаад тоглодог энэ байдал тогтоогдох юм бол Монгол Улс өөрөө энийг хуулиар хорьсон учраас үүн дээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал яригдана аа.

Тийм учраас хуулиар зөвшөөрөгдөөгүй үйлдлийг үйлдсэн тохиолдолд бид нар Эрүүгийн хуулиар санкцыг нэмэгдүүлсэн сурталчлах болоод бусад төрлийн зарим үйлдлүүдийг Зөрчлийн хуулиараа ингээд шийдвэрлээд явж байгаа гэсэн үг. Тэгэхээр Монгол Улс бол цахим мөрийтэй тоглоомыг хориглосон улсад тооцогдоно. Ер нь Азийн улсууд бол энэ цахим мөрийтэй тоглоомыг одоо жишээ нь цахим мөрийтэй тоглоом, тэр дотроо спорт төлбөрт таавар ч гэдэг юм уу ингэж зарим төрлийн үйлдлийг нь зөвшөөрөөд явдаг ийм улсууд байна. Гэхдээ одоо Азийн ихэнх улсууд бол яг энэ цахим мөрийтэй тоглоомыг бол бүхэлд нь энэ хориглох тал руугаа явж байгаа. Жишээ нь Сингапур бол эхлээд бол тэр төлбөрт тааврыг ч юм уу спорт төлбөр тааврыг ч юм уу тухайлан зөвшөөрөөд явж байсан боловч өнөөдөр энэ үйлдлүүдийг нь дотор нь ангилж ялгахад их бэрхшээлтэй байдаг учраас энэ цахим мөрийтэй тоглоомыг бол бүхэлд нь хориглоё гээд хуулиа гаргаад явж байгаа юм байна лээ.

Тэгэхээр ер нь Азийн улсууд бол бүгдээрээ л хориглох тал руу явж байна. Бат-Амгалан гишүүний хэлж байгаа тэр төлбөрт таавар и спорт бусад спортын төрлөөр хөгжүүлж байгаа энэ беттинг тавьдаг буюу нөгөө үр дүнг нь урьдчилан тооцох боломжтой үйлдлүүдийг нь өөрөө энэ нөгөө бооцоот гэж нэрлээд байгаа юм. Казино тэр мөрийтэй тоглоомын шинж агуулна гэхээр үйлдлийнх нь эцсийн үр дүн нь хэмжиж болдоггүй. Тэгэхээр түүгээрээ ялгаатай. Тэгэхээр судалгаа бол бүрэн хийгдэж дуусаагүй. Яг энэ мөрийтэй тоглоом дээр төлбөрт таавар дээр, бооцоот тоглоом дээр гээд.

Тэгэхээр энэ судалгааг бүрэн хийж чадаагүй байж байж би бид нар зарим төрлийг нь зөвшөөрөөд явчих юм бол үүн дээр нэг ийм хуулийн хийдэл үүснэ. Тийм учраас эхний түвшинд бол ингээд бүтэн хориглочихъё.

Цаашлаад бол яг тэр төлбөрт тааврыг ч юм уу, спорт төлбөр тааврыг ч юм уу тухайлан зохицуулъя гэх юм бол Сайнзориг гишүүний боловсруулж байсан тэр тухайлсан хуулийг гаргаад судалгааг бүрэн дүүрэн хийгээд тухайлан зохицуулах юм

бол ямар нэгэн хуулийн хийдэл үүсэхгүй юм байна л гэдэг ийм л төлөвлөгөөтэй байгаа.

Д.Амарбаясгалан: Энхтайваны Бат-Амгалан гишүүн тодруулж асууя.

Э.Бат-Амгалан: Тийм. Ерөнхийдөө бол яах вэ Учрал сайдын энэ оруулж ирж байгаа нэмэлт, өөрчлөлтийг бол ойлгож байгаа. Зүгээр миний асуугаад байгаа юм та хэдийн нөгөө судалгаагаар 100 хувь хорьчихлоо. Тэр нууц далд хэлбэрт буюу далд мөнгө угаалтын энэ эдийн засгийн эргэлтэд орж гадагшаа мөнгө гарах энэ боломж нь хэдий хэмжээгээр байдаг энэ талаар ер нь судалгаа байгаа юу? Би сая хэлсэн шүү дээ. Солонгос улс 100 хувь хорьсон боловчиг 2024 оны энэ судалгаагаар Зүүн өмнөд Ази ер нь Ази дотроо хамгийн өндөр хандалт авсан, ордог, оролцдог. Хэдий хуулиараа хорьсон боловч. Энэ тал дээр та хэд судалгаанууд байна уу л гэж. Нууц далд хэлбэрт ороход яг ямар ямар аюул нүүрлэх вэ? Бид бүхний технологийн хувьд чадахгүй, ойлгохгүй. Араас нь хүрэлцэж ажиллаж чадахгүй иймэрхүү асуудлууд байгаа юу?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгээс хариулт өгье. 4 дүгээр индэр.

Т.Батболд: Харилцаа холбооны зохицуулах хороо Зохицуулалтын газрын дарга Т.Батболд Бат-Амгалан гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье өө.

Цахим өрөөтэй тоглоомыг хязгаарласан тохиолдолд технологийн хувьд бол үндсэндээ 3 арга хэмжээ авна.

Нэгдүгээрт бол домэйн нэр болон ай пи хаягаар нь хандалтыг хязгаарлах арга хэмжээ авах боломжтой.

Хоёрдугаарт бол гар утасны үүрэн холбооны гар утасны дугаараар бүртгэлжүүлэх болно. Танин баталгаажуулах кодыг бол хязгаарлах арга хэмжээ авна.

Гуравдугаарт бол тухайн аппликэйшн мөрийтэй аппликэйшныг татах боломжийг IS-ийн апп стор болон Андройд апп стор дээр хязгаарлах бусад сайтуудыг бас хязгаарлах домэйн нэрээр нь авах бүрэн техникийн боломжтой байгаа. Мөн далд хэлбэр рүү шилжсэн тохиолдолд.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Т.Батболд: Далд хэлбэр рүү шилжсэн тохиолдолд банкны данснудаар нь дамжуулж хязгаарлах боломжийг энэ хуулийн дагуу бүрэн боломжтой болж байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Гадаадын хуулийн этгээд Монгол Улсад ийм бооцоот тоглоом зохион байгуулаад их хэмжээний иргэдийг татан оролцуулах юу байх вэ дээ. Иргэд оролцоод их хэмжээний мөнгө ингээд алдаад байгаа. Энийг бол зохих хэмжээнд шийдвэрлэх нь зүйтэй. Гэхдээ яах вэ асуулт сая давхацлаа л даа. Яг ингэж бүгдийг

нь хориглосноор далд хэлбэрт орохгүй юу гэж ингэж асуух гэж байсан юм. Яах вэ тэгээд хариулчихлаа л гэж үзэхээс дээ. Тэгээд өөр нэг хэдэн асуулт байгаа юм.

Нийт ер нь хохирогчдын тоо гэж гарсан уу? Хэдэн хүн хохирсон юм болоо? Яг энэ ажиллагаанаас болоод. Дээрээс нь энэ танилцуулга үзэл баримтлалд ийм өгүүлбэр байна тиймээ. Авлига албан тушаалын гэмт хэргийн замаар олсон мөнгийг угааж байгаа нөхцөл байдал тогтоогдсон гээд. Энэ бол их маш ноцтой ийм мэдэгдэл шахам үг л дээ. Тэгэхээр энэн дээр нэмэлт тодруулга авъя. Энэ ямар нөхцөл байдал тогтоогдсон, яг эзэн холбогдогч нь тогтоогдсон юм уу? Хэдэн төгрөгийн ийм асуудал байгаа юм бэ? Энэний мөрдөн шалгах ажиллагаа ямар түвшинд яваа юм бэ гээд.

Дараа нь зөвшөөрөлтэй хуулийн этгээд бол сар тутам 36.2 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний онцгой албан татвар ноогдуулах ийм зохицуулалттай юм байна. Гэхдээ бол энэ нь бол улсын татварт орлого болж орж ирдэггүй юм байна. Тэгэхээр энэ яагаад татвар хураагдахгүй татвараа төлөхгүй байна вэ гэдэг ийм асуулт байна. Түрүүний асуултыг асуусан. Иргэд өөрснөө хувиараа түүгээрээ гадаадын веб сайт нь мөрийтэй тоглох юм бол тэр хүн энэ хуулийн хамаарах субъект болох уу, хуульд. Тэр хүнийг мөрийтэй тоглосон гэж үзэх үү гэдэг ийм хэдэн асуулт байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгээс энэ Монголбанкнаас хүн ирээгүй юу? Энэ Монголбанк бас энэ хуулийн төслийг хэлэлцэхтэй холбоотойгоор ирүүлж байгаа материал дүгнэлт дээр яг энэ гадагшаа гарч байгаа мөнгийг яг зааглаж чаддаг юм уу? Энэ нь нөгөө onexpert-ээр гарч байна, энэ нь тэрүүгээр гарч байна гэж ялгаж зааглаж чаддаг юм уу? Энэ дээр нэмээд нэг хариулт өгөөдхөөрэй. Баярмаа гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг. 4 дүгээр индэр дээрээс. Албаны хүмүүс 4 дүгээр индэр дээрээс өөрсдөд хамаарах асуултад хариулт өгнө өө. Өөрийгөө танилцуулаад.

Г.Энхтайван: Монголбанкны дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван гишүүний асуултад тодруулъя.

Сүүлийн жилүүдэд крипто валюттай холбоотой гадаад гүйлгээний урсгал бол эрчтэй нэмэгдээд байгаа. 2021 онд цэвэр дүнгээрээ 120 сая доллар байсан бол өнгөрсөн 2024 онд 578 сая ам.доллар. Оны эхний хувьд улирлын байдлаар бол 87 сая доллар бол гадаад гүйлгээний Монгол Улсын эдийн засгийн харьяат болон харьяат бүсийн хооронд хийгдсэн крипто валютын гүйлгээгээр байгаад байгаа. 2021 оны гүйлгээнээс ингээд 4 дахин их нэмэгдсэнтэй холбогдуулан төв банкнаас тухайн үедээ блд хэд хэдэн бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд блд тухайн гүйлгээг илгээж байгаа банкаар нь дамжуулаад тухайн гүйлгээ хийж байгаа харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд нь илүү хяналт зохицуулалтыг хийж явуулж байгаа.

Тэгээд ерөнхийдөө ингээд тайланг нь харахад бол тухайн жил болгон аль банкаар хийж байгаа нь харьцангуй өөрчлөгдөөд яваад байдаг. Хамгийн тод жишээ гэх юм бол 2023 оны жишээн дээр харах юм бол Тээвэр хөгжлийн банк нэг ч гүйлгээ хийгээгүй байсан бол 2024 онд 162 гүйлгээ хийж байсан. Тэгээд 2024 ондоо энэ гүйлгээ нь огцом нэмэгдсэн байгаад байгаа. ХХБ-аар жишээлбэл харьцуулах юм бол 2024 онд огт гүйлгээ хийгдээгүй байсан бол 2021 онд нийт гүйлгээний 80 хэдэн хувь хийгдэж байсан байх. Тэгэхээр төв банкнаас тухайн арилжааны банк тус бүр дээр нь энэ сэжигтэй мөнгөн гүйлгээг мэдээлэхтэй холбогдуулсан одоо зөвлөмжийг

хүргүүлээд энэ дээр нь холбогдсон хяналт шалгалтыг хийгээд явж байгаа. Мэдээж энэ гүйлгээ илгээгчид маань өөрсдөө төв банкнаас энэ ирүүлсэн хяналт шалгалтын дараа тухайн банкаа солиод ингээд өөрчлөөд яваад байгаа.

Тэгэхээр бол энэ дээр нь арилжааны банк болгон тус бүрдээ энэ харилцагчийг таньж мэдэх энэ үйл ажиллагаагаа илүү нарийвчлаад зохицуулаад энэ харилцагчийг таньж мэдэж байгаа энэ процессоо илүү боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байгаад байгаа. Ер нь ингээд банкаа солиод л яваад байгаа гэсэн үг. Энэ дээр нь бол энэхүү хууль батлагдаад явсны дараа Төв банкнаас бол энэ үйл ажиллагааг бүүр нэлээн бууруулах тийм боломжтой гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Баярмаа гишүүний хариулт болов уу? Нэмж хариултууд өгье. Ажлын хэсгийнхэн.

Х.Сүрэнхорол: ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Сүрэнхорол.

Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн тоон мэдээллээр бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйл ангиар мөрийтэй тоглоом зохион байгуулах зүйл ангиар нийт 669 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулаад 200 хэргийг бол шүүхэд шилжүүлэх саналаа явуулаад 104 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн гэсэн тоон мэдээг цагдаагийн байгууллагаас ирүүлсэн тоон мэдээ байна аа.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Энхтайван дэд ерөнхийлөгч, 4 дүгээр индэр.

Г.Энхтайван: Баярмаа гишүүний асуулт нэмээд тодруулъя. Яг энэ гүйлгээ дээр бид бүхэн яг энэ мөрийтэй тоглоомын гүйлгээ байна, энэ цахим гүйлгээ байна гэдгийг бол яг илгээгчийн хувьд хянаж юу гэдэг юм шалгаад нарийн тогтоох боломж хүндрэлтэй. Тухайн гүйлгээ илгээгч маань өөрөө тухайн харилцагчийнхаа цаашаа явуулж байгаа гүйлгээний эрсдэлийг өөрөө хүлээдэг. Хүлээн авагч банк нь биш. Тэгэхээр тухайн харилцагч банк маань өөрөө тухайн харилцагчийг таньж мэдэх процесс дээр бол хамгийн анхны гүйлгээ яваад энэ дээр бол юу гэдэг юм энэ бол зөвхөн ийм крипто валютын гүйлгээ байна гээд мэдүүлээд явчихад эхний удаа тэгээд явчхаж байгаа. Дараагийн удаа энэ хэд хэдэн давтамжтайгаар ингээд яваад ирэх үеэр бол тухайн хүлээн авагч талаасаа илүү нягталсны үндсэн дээрээс бол энэ нь цахим мөрийтэй тоглоом байна уу, крипто байна уу, койн байна уу өөр юу байдаг юм. Асуулга авч байж.

Д.Амарбаясгалан: Дахин тодруулж асууя Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Хамгийн амархан уг нь асуултаас нь дахиад нэг асууя даа. Нөгөө гадаадын цахимаар гадаадын веб сайтад байгаа тэр цахим тоглоомоор тоглох юм бол энэ Монголын хуулийн хамаарах субъект болох уу гэдэг ийм. Энэ чинь нөгөө хуульчид нь ч юм уу хууль бичсэн хүмүүс нь хариулах хэрэгтэй байх л даа. Татвар ерөөсөө орж ирдэггүй юм байна лээ. Энэ яагаад орж ирдэггүй юм бол. Тэр нэг авлига албан тушаалын хэргийг энэ мөнгө угаах замаар энэ тоглосон байна гэсэн ийм өгүүлбэр байсан. Энэ нь юу гэсэн үг юм. Энийгээ тодруулаач гэсэн ийм 3 асуултыг л уг нь асуусан юм.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн ажлын хэсгийн гишүүний хувиар хариулт өгье.

П.Сайнзориг: Ажлын хэсэг ч биш байгаа юм. Манай ХЗБХ зүгээр Эрүүгийн хууль дээр нэлээн нухацтай үзэх ёстой гээд ажлын хэсэг зүгээр тэр чиглэл рүү гаргасан. Баярмаа гишүүний би зүгээр эхний асуултад хариулъя.

Гол асуудал маань бол энэ цахим орчинд буюу энэ орон зай нь угаасаа үл хамаараад тоглох боломж байгаа. Энэ рүү ороод ингээд тоглох юм бол Монгол Улсын хууль тогтоомж үйлчлэхгүй боломжгүй байгаа. Бид энэ хуулиудын өөрчлөлтөөр юу хийж байна гэхээр эдгээр тэр сервер нь гэдэг юм уу зохион байгуулалт нь гадаад улсад байгаа этгээдэд энэ мөнгө төгрөгийг нь Монгол Улсаас шилжүүлэхэд дэмжлэг үзүүлж байгаа утасны дугаараа ашиглуулахаас эхлээд банкны дансаа ашиглуулахаас эхлээд тодорхой үйлдлүүдийг нь гэмт хэрэгт тооцож энэ агент гэдэг юм уу даа энэ агентаар ажиллаж байгаа хүмүүсийн үйл ажиллагааг хууль бус гэж үзэж энэ дээр нь тодорхой хэмжээний хариуцлагын асуудал ярина гэдэг байдлаар аль болохоор юу гэдэг юм энэ асуудлыг хязгаарлахыг хүсэж байгаа.

Ер нь зүгээр гадаад төлбөр тооцооны хэрэгсэл буюу банкны картаа шууд олон улсын.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Олон улсын сайттай холбоод шууд тоглоод мөнгөө алдах юм бол энэ зохицуулах боломжгүй. Энэ хувь хүний ухамсрын асуудал.

Тийм учраас энийг л цаашдаа түрүүн Учрал сайд хэлсэн. Нэлээн ултай суурьтай хандъя аа. Тодорхой хэмжээнд яах вэ зүгээр спортын тэр бэйтийн үйл ажиллагаа ч гэдэг юм уу тэр Бат-Амгалан гишүүний асууж байгаа асуултын хүрээнд судалгааг нь хийж үзье гэж байгаа юм. Тэгээд сайн үзье. Энэ дээр нь юу гэдэг юм банкны карт авахаас нь эхлээд олон улсын гүйлгээн дээр нь мөнгөн дүнгээр нь хязгаарлах боломж энэ тэр шүүхийн оролцоотой хийж болох уу үгүй юу? Энэ ч гэсэн өнөөдрийн зүгээр Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн хүрээнд зохицуулалт болно.

Тэгэхдээ одоогоор бол зохицуулалт байхгүй. Энэ асуудлуудыг нэлээн сайн судалъя л гэдэг ийм байдалтай байгаа. Тэгээд эхний ээлжид тодорхой богино хугацаанд энэ үйл ажиллагааг хязгаарлах энэ арга хэмжээг энэ Зөвшөөрлийн хууль болон холбогдох улсын хуулиар авъя. Тэгээд цаашдаа бид хэд энэ асуудлуудыг нэлээн ултай суурьтай судалъя л гэсэн ийм байдалтайгаар ерөнхийдөө шийдвэрт хүрэх гээд л явж байна л даа.

Д.Амарбаясгалан: Баярмаа гишүүн дахин тодруулж асууя.

Ж.Баярмаа: Түрүүний 2 асуултын хариулт ирэхгүй юм байна, хариулах хүн байхгүй юм байна. Өөр нэг асуулт асуух гэсэн юм.

Одоо энэ чинь нөгөө миний ойлгосноор цахим мөрийтэй тоглоомыг хориглодог байсан. Мөрийтэй тоглоомыг. Тэгэнгүүт цахим гэдэг энэ нэр томъёог оруулж ирж хориглох гэж байна. Тэгэнгүүт өмнө нь хуулиар зохицуулагдаагүй байсан гэж үзээд тэр цахимаар энэ зохион байгуулаад асар олон хүн хохироочихсон байгаа энэ асар их мөнгөн дүн бүхий хохирогч бүхий энэ гэмт хэргүүд тухайн үед зохицуулалтгүй байсан гэж үзээд хариуцлага ноогдохгүй юу гэдэг ийм асуултыг асуугаад тэгээд больё доо.

Д.Амарбаясгалан: Учрал сайд.

Н.Учрал: Одоо энэ Зөвшөөрлийн хууль дээр 2 төрлийн зөвшөөрлийг ингээд хуульчилчихсан байсан. Спорт төлбөр таавар, тэр бооцоот тоглоом гээд. Тэгээд бооцоот тоглоом, спорт төлбөр таавар гэж нэрлэж байгаа мөртөө мөрийтэй тоглоомын шинж агуулж байгаа төрөл бүрийн аппликэйшнээр дамжуулаад гадагшаа тэр мөнгөн урсгал гарсан. Жилд тэр 500 сая доллар гадагшаа гараад явчихжээ. Тэгээд энэ бол зөвшөөрсөн үйлдэл гэж тайлбарлаад байдаг. Энэ чинь зөвшөөрчихсөн шүү дээ гээд. Тэгээд тухайн үед энэ Зөвшөөрлийн хуулийг хэлэлцэж байхад энэ яасан бэ гэхээр бие даасан хуулийг нь гаргаад шаардлагуудыг нь тавьсны дараа энэ зөвшөөрлийг олгоно шүү гэсэн чинь хувийн компани шүүхэд өгөөд тэгээд Дээд шүүхийн эцсийн шийдвэр гарангуутаа зөвшөөрөл өгөх ёстой гээд ингээд зөвшөөрөл олгогдчихсон юм байна л даа.

Тэгээд тэр цаг үеэс авхуулаад ерөөсөө энэ Монгол Улсад зөвшөөрөгдсөн юм шиг яваад ирчихсэн. Тэгэхээр энэ хуулиар энэ зөвшөөрлүүдийг нь энэ хуулиар өөрчилж байна шүү дээ.

Нэг ёсондоо Монгол Улс бүхлээр нь цахим мөрийтэй тоглоомыг ч бай, төлбөрт тааврыг ч бай, бооцоот тоглоомыг ч бай бүхэлд нь.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Н.Учрал: Тэгээд бүхэлд нь тэр үйлдэл болгоныг нь хориглоод жишээ нь тоглохыг нь, зуучлахыг нь, дэмжлэг үзүүлэхийг нь, сурталчлахыг нь ингээд бүхэлд нь хориглочихоор одоо бол энэ өөрөө нөгөө хариуцлага нь тодорхой болж байгаа юм. Эрүүгийн хуулиар Зөрчлийн хуулиар. Тэгээд эхлэхээр бол одоо энэ хууль зөрчсөн үйлдэл гэдэг нь тогтоогдоно. Тэгээд хуулийн хариуцлага бол хүлээнэ. Өнгөрсөн хугацаанд гадагшаа тэр гарч явсан татваргүйгээр гарч явсан ч юм уу энэ үйлдлүүд дээр бол одоо ч гэсэн эрүүгийн хуулиар хариуцлага хүлээх бололцоотой. Тэнд ямар нэгэн мөнгө угаахын шинж тэмдэг байна уу, татвараас нуун дарагдуулах ямар нэгэн үйлдэл байна уу гэдгийг тогтоох ёстой.

Тийм учраас ер нь Монголбанкн дээр ч бай бид нар цаашдаа энэ цагдаагийн байгууллага ч гэсэн яг ийм технологийн хувьд бэлэн байдал руу шилжих түүн дээр нь хяналт тавих ийм технологийн бэлэн байдлаа бол сайжруулж байж л үүнтэй бүрэн тэмцэх юм байна л даа. Тийм учраас эхлээд ямар ч байсан хориглож авъя. Тэгээд бэлэн байдлуудаа хангаад ингээд хариуцлагаа ярья л гэж.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүн Уянгахишиг гишүүн нэмэлт хариулт өгье.

Г.Уянгахишиг: Энэ дээр Баярмаа гишүүний асууж байгаа асуулт яг зөв л дөө. Тэгээд анх өргөн баригдсан хуулийн төсөл дээр бол 20.18 дээр нэмэхдээ цахим мөрийтэй тоглоом гэж байсан. Энэ нь бол яг хэлэлцүүлгийн явцад бол энэ 20.17 дээр мөрийтэй тоглоомыг олон нийтийн газар эсвэл мэдээллийн технологи ашиглана гэж байгаа юм. Тэгэхээр яг энэ мэдээллийн технологи ашиглана гэдэг дотор бол цахим мөрийтэй тоглоом орчхож байгаа. Өөрөөр хэлэх юм бол энэ хуулийн өөрчлөлтөөр биш өмнө нь угаасаа л Эрүүгийн хуулийн 20.17-оороо цахим мөрийтэй тоглоом гэмт хэрэгт тооцогдож байсан гэсэн үг.

Харин яаж орж ирж байгаа вэ гэхээр 20.18 дээр орж байгаа нь мөрийтэй тоглоомд хамаардаггүй буюу төлбөр таавар бооцоот тоглоомын үйл ажиллагааг эрхэлсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцохоор орж ирж байгаа. Энэ нь яг нөгөө зарчмын зөрүүтэй саналаар орж ирсэн томъёолол олон нийтийн газар эсвэл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор төлбөр таавар эсвэл бооцоот тоглоом зохион байгуулсан бол.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Г.Уянгахишиг: Гэж орж ирж байгаа. Тэгэхээр энэ нь ямар агуулгатай вэ гэхээр одоо энэ хуулийг батлахаас энэ хуулийг батлагдаагүй байхад Эрүүгийн хуулийн 20.17-д цахим мөрийтэй тоглоом гэдэг нь ордоггүй байсан юм гэдэг асуудал байхгүй. Цахимаар мөрийтэй тоглосон бол орно. Өмнөх асуудлын хувьд одоо жишээлбэл гадаадын хуулийн этгээд эрхэлж байгаа гадаадад байгаа нөгөө цахим орчин чинь хил хязгаарын ойлголт байхгүй учраас хэрвээ тэр үйл ажиллагааг эрхэлж байгаа нь гаднын хуулийн этгээд байгаа тохиолдолд яг Монгол Улсын хуулиар бол хариуцлага хүлээлгэж чадахгүй байгаа. Энэ хууль батлагдсан ч чадахгүй. Гэхдээ яг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр орж ирж үйлчилж байгаа хэсэг нь бол яг банкны дансаа ашиглуулах цахим токеноо ашиглуулах гэх мэтийн яг энэ үйлдлүүд дээр бол 20.19-өөр гэмт хэрэгт тооцох энэ зохицуулалтыг оруулж ирсэн байгаа гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос санал хураалгахаар зарчмын зөрүүтэй 5 санал байгаа юм байна.

Энэ Эдийн засгийн байнгын хороо дөхөж байна уу?

Олон гишүүд Байнгын хорооны хуралд орж суучхаад хөгжлийн төлөвлөгөө хэлэлцэж байгаа учраас бас тэнд их төвлөрөөд байна тийм ээ.

Тэгэхээр ингэе санал хураалтыг хойшлуулъя. Хөгжлийн төлөвлөгөөг Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэж дуусахгүй байгаа учраас өнөөдрийн чуулганыг хаагаад ирэх даваа гаргийн өглөө 11 цагаас, мягмар гаргийн өглөө 10 цагаас энэ хэлэлцэж байгаа асуудлуудыг үргэлжлүүлэн хэлэлцэж дуусгана аа.

Чуулган хаалаа.

14.47 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА